

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН “КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ”, “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ” БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ӨӨРИЙН ДҮРМИЙН САНГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ НИЙТЭД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХААР ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны (хувьцааны) танилцуулгад хөрөнгө оруулагч танд хувьцаа худалдан авах шийдвэр гаргахад туслах, шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйлийг танилцуулгад заасан газраас болон Андеррайтерын компанид хандаж авна уу.

АГУУЛГА

Нэр томъёоны лавлах	5
Товч танилцуулга.....	6
Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө.....	7
Үнэт цаас гаргахад оролцсон байгууллагуудын мэдээлэл.....	8
Компанийн шийдвэр гаргалтад оролцсон эрх бүхий этгээдүүдийн мэдээлэл.....	9

НЭГ. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1 Үнэт цаас гаргагч компанийн хаяг.....	10
1.2 Үнэт цаас гаргагч компанийн бүртгэлийн товч мэдээлэл	10
1.3 Үнэт цаас гаргагч компанийн байршил	11
1.4 Үнэт цаас гаргагч компанийн түүх	12
1.5 Үнэт цаас гаргагч компанийн бүтэц, зохион байгуулалт, салбар төлөөлөгчийн газрын танилцуулга.....	15
1.6 Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлогын талаарх мэдээлэл ...	17
1.7 Үнэт цаас гаргагч компанийн 5-с дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн танилцуулга	18
1.8 Эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл.....	19
1.9 Үнэт цаас гаргагч компани, хяналтын багц эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өр төлбөрийн талаарх тодорхойлолт	21
1.10 Компанийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл.....	21
1.11 Сүүлийн 3 жилийн болон үнэт цаас гаргахаар зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд /мянган төгрөг/.....	27
1.12 Үнэт цаас гаргагч компанийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл, хууль зүйн хараат бус дүгнэлт.....	30
1.13 Үнэт цаас гаргагч компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний талаарх үнэлгээний байгууллагын дүгнэлт	32
1.14 Үнэт цаас гаргаж санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл	35

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

2.1 Үнэт цаасны мэдээлэл	36
2.2 Үнэт цаасыг нийтэд санал болгох шийдвэр.....	37
2.3 Үнэт цаас эзэмшигчийн эрх.....	37
2.4 Урьд гаргасан үнэт цаасны талаарх мэдээлэл.....	39
2.5 Хувьцааны шинэчилсэн үнэ тогтоох.....	40
2.6 Хувьцаа хуваах төсөл	41
2.7 Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график	43
2.8 Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график	43
2.9 Lock up.....	49

2.10 Үнэт цаас гаргах замаар хуримтлуулах хөрөнгийг зарцуулах төслийн товч танилцуулга, эдийн засаг үр ашгийн тооцоо.....	49
2.11 Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ	64
2.12 Үнэт цаасыг зуучлагч андеррайтерын компанийн мэдээлэл.....	67
2.13 Үнэт цаасны тухай мэдээлэл, дэлгэрэнгүй танилцуулгатай танилцаж болох газар, хариуцах мэргэжилтэн, холбоо барих мэдээлэл.....	68

ЗУРАГНУУД

<i>Зураг 1 Компанийн байршил</i>	11
<i>Зураг 2 Хувьцаа эзэмшигчдийн тоо, бүтэц</i>	15
<i>Зураг 3 Бүтэц зохион байгуулалт</i>	16
<i>Зураг 4 Үйлдвэрийн хүчин чадал ашиглалт</i>	27
<i>Зураг 5 Хувьцааны арилжаалагдсан ширхэг, үнэ.....</i>	40
<i>Зураг 6 Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр</i>	44
<i>Зураг 7 Хувьцааны захиалга.....</i>	44
<i>Зураг 8 Хөрөнгө оруулалтын задаргаа</i>	54
<i>Зураг 9 Хөрөнгө оруулалтын өгөөж</i>	63

ХҮСНЭГТҮҮД

<i>Хүснэгт 1 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө</i>	7
<i>Хүснэгт 2 Цехүүдийн боловсон хүчин</i>	17
<i>Хүснэгт 3 Үнэт цаас эзэмшигчдийн мэдээлэл</i>	19
<i>Хүснэгт 4 ТУЗ-ын гишүүдийн мэдээлэл.....</i>	19
<i>Хүснэгт 5 Удирдлагын багийн гишүүд</i>	21
<i>Хүснэгт 6 Компанийн үйлдвэрлэл</i>	22
<i>Хүснэгт 7 Ашиглахаар төлөвлөж буй шохойн чулууны ордын шохойн чулууны эрдэсийн найрлага</i>	24
<i>Хүснэгт 8 Сүүлийн 3 жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ</i>	26
<i>Хүснэгт 9 Орлого зарлагын бүтэц.....</i>	27
<i>Хүснэгт 10 Баланс</i>	28
<i>Хүснэгт 11 Орлогын тайлан.....</i>	29
<i>Хүснэгт 12 Компанийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл.....</i>	31
<i>Хүснэгт 13 Хөрөнгийн үнэлгээний товч.....</i>	33
<i>Хүснэгт 14 Хөрөнгийн үнэлгээний засвар оруулсан баланс</i>	34
<i>Хүснэгт 15 Бизнесийн үнэлгээ</i>	35
<i>Хүснэгт 16 Хувьцаа эзэмшигчдийн судалгаа</i>	40
<i>Хүснэгт 17 Хувьцааны арилжаа судалгаа</i>	40
<i>Хүснэгт 18 Шинэчилсэн үнэ тогтоох тооцоо</i>	41
<i>Хүснэгт 19 Хувьцаа хуваах тооцоо</i>	43
<i>Хүснэгт 20 Анхдагч зах зээлд байршуулах цаг хугацааны график.....</i>	45
<i>Хүснэгт 21 Хөрөнгө оруулалтын зарцуулалт.....</i>	49
<i>Хүснэгт 22 Хөрөнгө оруулалтын зарцуулалт.....</i>	50
<i>Хүснэгт 23 Үйл ажиллагааны төлөвлөгөө</i>	50
<i>Хүснэгт 24 Зээлийн мэдээлэл.....</i>	51
<i>Хүснэгт 25 Зээлийн зарцуулалтын мэдээлэл</i>	53

Хүснэгт 26 Хөрөнгө оруулалтын тооцоо	55
Хүснэгт 27 Бүтээгдэхүүний өртөг	56
Хүснэгт 28 Бүтээгдэхүүн хэрэглэгч	58
Хүснэгт 29 Олборлосон шохойн чулууны ордын бүхэл шохойн эрдэсийн найрлага	59
Хүснэгт 30 Ашиглахаар төлөвлөж буй шохойн чулууны ордын шохойн чулууны эрдсийн найрлага	59
Хүснэгт 31 Бүтээгдэхүүний чанар	60
Хүснэгт 32 Шохойн зуухыг шинэчилснээр бүтээгдэхүүний чанар	60
Хүснэгт 33 Шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо	60
Хүснэгт 34 Тооцоолсон орлогын төлөвлөгөө	61
Хүснэгт 35 Орлогын тайлангийн бүтэц	61
Хүснэгт 36 Мөнгөн урсгалын төлөвлөгөө	62
Хүснэгт 37 Хөрөнгө оруулалтын өгөөж	62

ХАВСРАЛТ

Хавсралт 1 Хуулийн компанийн дүгнэлт	
Хавсралт 2 Аудитын компанийн дүгнэлт	
Хавсралт 3 Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан	
Хавсралт 4 Андеррайтеры компанийн дүгнэлт	
Хавсралт 5 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн болон холбогдох гэрчилгээний хуулбарууд	
Хавсралт 6 Эрх бүхий этгээдийн холбогдох тогтоол шийдвэрүүд	
Хавсралт 7 Нэмж үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлсэн ХНХ-ын протокол	
Хавсралт 8 Үнэт цаас бүртгүүлэх тухай СЗХ-нд гаргасан хүсэлтийн хуулбар	
Хавсралт 9 СЗХ-ны тогтоолын хуулбар	

НЭР ТОМЪЁОНЫ ЛАВЛАХ

Ам.доллар	Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт
Андеррайтер	Уг үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажлыг гүйцэтгэж буй “БиДиСЕК” ХК
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
БДК	Брокер, дилерийн компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Валютын ханш	Монгол Банкны тухайн өдрөөрх төгрөгийн бусад валюттай харьцах мөнгөн нэгж
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
МУ	Монгол улс
МХБ	Монголын хөрөнгийн бирж
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОХУ	Оросын Холбооны Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
ТИС	Технологийн их сургууль
Тн	Тонн
Төгрөг	Монгол Улсын мөнгөн тэмдэгт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
Үнэт цаас гаргагч	Үнэт цаас гаргаж санхүүжилт татан төвлөрүүлж буй “Силикат” Хувьцаат Компани
Үнэт цаасны код	“Силикат” ХК-ийн МХБ-ийн арилжааны код болох SIL
ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХК	Хувьцаат компани
ХНХ	Хувь нийлүүлэгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШЗ	Хянан шалгах зөвлөл
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМНД	Эрүүл мэнд, нийгмийн даатгал
EPS	Earning Per Share
P/E	Price /earnings ratio
ROE	Return on Equity

ХИМИЙН НЭР ТОМЪЁО

CaCO ₃	Кальцийн карбонат
CaO	Кальцийн оксид
CO ₂	Нүүрс хүчлийн хий
MgO	Магнийн оксид
pH	Бодисын орчны хүчиллэг, шүлтлэгийг хэмждэг хэмжүүр

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч компани нь анх 1966 онд байгуулагдаж барилгын материал, шохойн үйдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 1992 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болсон түүхтэй. Тус компани нь анх байгуулагдсанаас хойш эдүгээ 45 жил болоод байна.

Компанийн хувьцааны хэт төвлөрлөөс хамаарч хувьцааны зах зээлийн үнэ, бодит үнийн хооронд ихээхэн зөрүү үүссэн тул 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээрх нэгж хувьцааны дансны үнээр хувьцааны нэрлэсэн үнийг шинэчилж тогтоон 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30 112 302 ширхэг хувьцаатай байхаар тогтсон. Тус компанийн 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу нэгж хувьцааны дансны үнэ 17 765 байсан бөгөөд нэгж хувьцаа тус бүрийг 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй байхаар шинэчлэн тогтоож, нэгж хувьцааг 177 ширхэгт хуваасан болно.

Тус компанийн үйл ажиллагаа нь 1998 оноос зогсонги байдалд орсон байсныг одоогийн өмчлөгч болон удирдлагын зүгээс 2005 оноос дахин үйл ажиллагаанд нь оруулах ажлыг хэсэгчлэн эхлүүлсэн болно. Цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангаж өр төлбөрийг барагдуулах, хүчин чадлыг нэмэгдүүлж технологийн шинэчлэл хийхэд 3 650 000 000 төгрөг шаардлагатай ба тус хөрөнгийг компанийн 35 хувьтай тэнцэх 16 222 300 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон татан төвлөрүүлэх замаар санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна.

Одоо ажиллаж байгаа үйлдвэрлэлийн бааз, дэд бүтцэд тулгуурлан өндөр чанартай, бага өртөгтэй, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх сүүлийн үеийн технологитой үйлдвэрийг Монголын шохойн үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэн ашиглах нь төслийн нэг үндэслэл болж байгаа.

Энэхүү шохойн үйлдвэрийг ашигласнаар:

- Шохойн үйлдвэрийн үндсэн түүхий эд нүүрс, шохойн чулууны технологийн ашиглалт 65-75% байсан бол нүүрс нь 100%, шохойн чулууны ашиглалт 90% болно.
- Шохойн өөрийн өртөг буурч, чанар сайжирсанаар шохойн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- Экологийн цэвэр үйлдвэрлэл явагдаж дутуу шаталтаас үүсэх нүүрс хүчлийн хийн ялгаралт эрс буурна.
- Шохойн чанар, стандарт олон улсын түвшинд хүрнэ.
- Шохойн чанар, хямд өртгийг дагаж хөнгөн бетон блокны чанар сайжирч өртөг хямдрана.
- Карьерийн бутлах, ангилах үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт дээшилнэ.
- Чанар дагаж борлуулалт нэмэгдсэнээр, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт 100%-д хүрнэ.
- Дотоодын зах зээлийг хангаад зогсохгүй, бүтээгдэхүүнээ экспортлох бололцоотой болно.

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаасыг анхдагч зах зээлд захиалгын бүртгэлийн аргаар байршуулна. Үнэт цаасыг олон нийтэд СЗХ болон МХБ-ийн зөвшөөрөл гарсанаас хойш 3 долоо хоног танилцуулагдах ба 3 дахь долоо хоногоос эхлэн брокер дилерийн компаниудаар дамжуулан хувьцааны захиалгыг 1 долоо хоногийн турш хүлээн авсны дараагаар захиалга дүгнэх, үнэ тогтоох, анхдагч зах зээлд байршуулах зэрэг ажиллагаа гүйцэтгэгдэнэ.

	1 дахь долоо хоног	2 дахь долоо хоног	3 дахь долоо хоног	4 дахь долоо хоног	5 дахь долоо хоног	6 дахь долоо хоног	7 дахь долоо хоног
СЗХ-ний тогтоол, МХБ-ийн бүртгэл	Үнэт цаасыг олон нийтэд санал болгох нөхцөл бүрдэх						
Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах		Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, брокерийн компаниудын цахим хуудас, и-мэйл зэргээр танилцуулга хийх					
Захиалга авах, хаах				Брокер дилерийн компаниудаар дамжуулан доод үнийг 225 төгрөг болон түүнээс дээш үнээр ажлын 5 хоногийн хугацаанд захиалга авах бөгөөд захиалгыг долоо хоногийн сүүлийн ажлын өдрийн үнэт цаасны арилжааны цаг дуусмагц хаана.			
Захиалга дүгнэх, үнэ тогтоох					Нийт захиалгыг хүлээн авч анхдагч зах зээлд худалдах үнийг ажлын 3 хоногт багтаан зах зээлийн эрэлтэд тулгуурлан үнэт цаас гаргагч болон андеррайтер хамтран тогтооно.		
Арилжаалах зөвшөөрөл авах					Анхдагч зах зээлийн арилжаа хийх зөвшөөрөл авах хүсэлтийг ажлын 2 өдөрт багтаан СЗХ-нд гаргана		
Анхдагч зах зээлийн арилжаа						Зөвшөөрөл олгогдсоноос хойш ажлын 2 хоногт багтаан МХБ-ийн үнэт цаасны арилжаагаар хувьцааг нийтэд худалдах ажиллагааг зохион байгуулна	
Тайлан гаргаж СЗХ-нд өгөх						Үнэт цаасны арилжааны тайланг СЗХ-нд гарган өгөх ба ХНХ зарласан мэдээллийг хавсарган хүргүүлнэ	
ХНХ болох							Хурал зарласнаас хойш 30 хоногийн дараа хуралдана

Хүснэгт 1 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

**ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН
МЭДЭЭЛЭЛ**

Аудит	<p>“Сүлд Аудит” ХХК Хаяг: УБ, ЧД, 4-р хороо, нэгдсэн үндэсний гудам, бага тойруу 6/7 Холбоо барих утас: 70118016 Вэб сайт: www.suld-audit.mn И-мэйл хаяг: gundbayar@suld-audit.mn</p>
Хууль	<p>“Монгол Өмгөөлөгч” хууль зүйн фирм Хаяг: УБ, СБД, 1-р хороо, Гранд оффис төв, # 201 Холбоо барих утас: 70129206 Вэб сайт: www.advocate.mn И-мэйл хаяг: info@advocate.mn</p>
Үнэлгээ	<p>“Үндэсний Реалти” ХХК Хаяг: УБ, ЧД, 4-р хороо, нэгдсэн үндэсний гудам, бага тойруу 6/7 Холбоо барих утас: 99182632 И-мэйл хаяг: b_naraa2@yahoo.com</p>
Ордын ТЭЗҮ боловсруулалт	<p>“Эвсэг Монгол” ХХК Хаяг: УБ, ЧД, Жуулчны гудам -34, Мон-Ар ХХК-н байр, 4 давхар Холбоо барих утас: 70111711,</p>
Андеррайтер	<p>“БиДиСек” Хувьцаат Компани Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК” ХК-ийн төв оффис Холбоо барих утас: 11-312030 Вэб сайт: www.bdsec.mn И-мэйл хаяг: info@bdsec.mn</p>

**КОМПАНИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ОРОЛЦСОН ЭРХ БҮХИЙ
ЭТГЭЭДҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ**

№	Овог нэр	Мэргэжил	Хаяг
1	Даваасүрэн Туул	Хуульч, эрх зүйч	“Силикат”ХК-ийн ТУЗ-ийн дарга УБ, ЧД, 1-р хороо, 1-40000 8-6 тоот
2	Цэрэннадмид Содбилэг	Филисофи	“Силикат” ХК-ийн гүйцэтгэх захирал УБ, ЧД, 8-р хороо, 31-49 тоот
3	Цэрэннадмид Сэргэлэн	Уулын баяжуулагч	“Силикат” ХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн захирал УБ , БГД, 8-р хороо, 9Б-32 тоот
4	Цэрэннадмид Болормаа	Нягтлан бодогч	“Силикат” ХК-ийн нягтлан бодогч Дархан Уул аймаг, 10-р баг 54- ийн 276 тоот
5	Дорж Энхболд	Бүрэн дунд	“Силикат” ХК-ийн борлуулалт хариуцсан менежер УБ, БЗД, 4-р хороо, 200-39 тоот
6	Володя Мөнхтуяа	Эдийн засагч	“Агч трейд” ХХК-ийн нягтлан бодогч УБ, ЧД 8-р хороо, 31-49 тоот
7	Нямдаш Цогцлон	Хуульч	“Силикат” ХК-ийн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал Дархан Уул аймаг, 15-р баг 6-р хэсэг 12 тоот
8	Мягмарсүрэн Наранзул	Барилгын материалын технологич	“Силикат” ХК-ийн технологич Дархан Уул аймаг, 14-р баг 1а-89 тоот
9	Бямба Сэр-Од	Барилгын материалын технологич	“Силикат” ХК-ийн технологич инженер Дархан Уул аймаг, 3-р баг 2-6 тоот
10	Жалбуу Ганболд	Бизнесийн удирдлага, эдийн засагч	“Силикат” ХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал УБ, ЧД, 6-р хороо, 6-р хороолол 31-11 тоот

НЭГ. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХАЯГ

Компанийн төв байр:

Дархан – Уул аймаг, Үйлдвэрийн дүүрэг, “Силикат” хувьцаат компанийн байр

Утас: 01-37-2024755

Факс: 01-37-2024755

Улаанбаатар хот дахь салбар:

УБ, СБД, Сөүлийн гудам, Чонон Бөрт төв, # 306

Утас: 976- 70117116

Факс: 976-70117116

Вэб сайт: www.silikat.mn

И-мэйл: info@silikat.mn

1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Компанийн оноосон нэр:	“СИЛИКАТ” ХК
Байгуулагдсан огноо:	1966 он
Улсын бүртгэлийн дугаар:	1910010007
Регистрийн дугаар:	2050463
Газар эзэмших гэрчилгээний дугаар:	0079244
Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний дугаар:	Ү-20030010435, Ү-2003006765, Ү-20030011621
Нийт эзэмшдэг үйлдвэрийн тайлбайн хэмжээ:	43000 м2
Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	Шохой болон хөнгөн бетон үйлдвэрлэл, элс, шохойн чулуу олборлох

Эзэмшиж буй ашигт малтмалын орд

Шохойн чулуун орд:	14949А ашиглалтын лицензийн дагуу эзэмшиж буй үйлдвэрээс 4 км зайд байрлах нийт 25 га талбайг хамарсан шохойн чулуун үндсэн орд
Элсний орд:	3998Х лицензийн дагуу эзэмшиж буй үйлдвэрээс 9 км зайд байрлах нийт 31га талбайг хамарсан элсний орд

1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БАЙРШИЛ



Зураг 1 Компанийн байршил

Үйлдвэр нь Улаанбаатар хотоос 220 км-т орших, Монгол Улсын барилгын материалын хамгийн том бүс нутаг болох Дархан-Уул аймгийн үйлдвэрийн дүүрэгт байрладаг.

Дархан уул аймаг нь газар зүйн байрлалын хувьд барилгын материалын түүхий эд болон нүүрс, алт мөн төмрийн арвин нөөцтэй бүс нутагт тооцогддог.

1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ

1966 - 1992	<p>Тус үйлдвэр нь Бүгд Найрамдах Польш Ард Улсын техник-эдийн засгийн тусламжаар Дархан хотод 1966 онд шохой ба цагаан тоосгоны үйлдвэр нэртэйгээр анх ашиглалтанд орсон. Жилдээ 22 мянган тонн шохой, 29 сая ширхэг тоосго, хоногт 60-70 тонн 60-70%-ийн идэвхжилтэй шохой, 100-120 мянган ширхэг 100-150 маркийн силикат тоосго үйлдвэрлэж, манай улсын ханын материалын хэрэгцээний 25%-г дангаар хангаж байсан үндэсний томоохон үйлдвэрийн нэг юм.</p> <p>Үйлдвэр ашиглалтанд орсноос хойш зогсолтгүй тогтвортой ажиллаж байх үедээ буюу 1966-1992 он хүртэл нийт 900 гаруй сая ширхэг силикат тоосго, 450 мянган тонн шохой үйлдвэрлэж дотоодод болон ОХУ-д экспортлож байв.</p>
1992 - 1998	<p>Монгол Улсын өмч хувьчлалын комиссын 1992 оны 40-р тогтоолоор хувьчлагдан “Силикат” ХК болон зохион байгуулагдсан. Үйлдвэрлэлийн техник технологийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага тулгамдсаар ирсэн боловч тухай бүрт асуудлыг шийдвэрлэх нөхцөл бололцоо бүрдэхгүй байсаар өнөөг хүрсэн болно.</p> <p>1992 оноос хойш үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, үр ашгийн түвшин буурсаар 1998 оноос үйлдвэрлэл бүрэн зогссон. Энэ нь нэг талаар социалист систем задран унаж, эдийн засгийн хямрал бүх салбарт /1989-1999/ нөлөөлсөнтэй холбоотой.</p>
1998 - 2006	<p>Барилгын салбар зогсонги байдалд орсноор тоосгоны хэрэглээ буурч, үйлдвэрийн бүх шатны тоног төхөөрөмж элэгдэж хуучирсанаас шалтгаалж ажиллах бололцоогүй болон зогссон.</p>
2004 - 2005	<p>Компанийн одоогийн удирдлагын баг нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр, улс орны эдийн засгийн өсөлттэй уялдан барилгын салбар эрчимтэй сэргэж байгаа байдалд дүгнэлт хийн, барилгын материал үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт хийх зорилго тавьж, судалгаа хийсний үндсэн дээр Дарханы “Силикат” ХК-ийг сонгон хөрөнгө оруулалт хийн худалдан авах шийдвэр гаргасан. Тус үйлдвэр нь дэд бүтцээр бүрэн хангагдсан төдийгүй гол түүхий эдийн орд газрыг эзэмшдэг зэргээр шийдвэр гаргалтад бүрэн нөлөөлсөн.</p> <p>Одоогийн удирдлагын баг нь 2004 онд хяналтын багцыг авч, 2005 онд компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчилсэнээр үйлдвэрийг сэргээн ажиллуулах шийдвэр гаргасан.</p>
2005 - 2006	<p>2006 оноос эзэмшигчдийн хөрөнгөөр (480 сая төгрөг) олон жилийн зогсолтын улмаас ажиллагаагүй болсон технологийн шугамыг засварлан шинэчилж тоосгоны үйлдвэрийг ажиллуулж, 350 мянган ширхэг цагаан тоосго үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн. Тухайн үед барилга угсралтын технологийн</p>

	шинэчлэлээс хамаарч тоосгоны зах зээлийн эрэлт хэрэгцээ буурч, зах зээлд хөнгөн бетоны эрэлт хэрэгцээ сэргэсэн байсан. Мөн цагаан тоосго нь хэдий сайн чанартай байсан ч, өртөг өндөр байсан тул хямд үнэтэй энгийн улаан тоосготой өрсөлдөх боломжгүй болсон байлаа.
2006	2006 онд цагаан тоосго үйлдвэрлэх технологийн шугамыг хөнгөн бетоны үйлдвэрлэлийн техник технологт шилжүүлэх, шохойн үйлдвэрийн 4 зууханд их засвар хийх, хүчин чадлыг өргөтгөх төсөл боловсруулсан.
2007	Дээрх төслийг хэрэгжүүлэхээр Зоос банктай хөрөнгө оруулалтын зээлийн гэрээ байгуулав.
2007 оны 7 сард	Зоос банкны 21 тоот зээлийн гэрээгээр 441 115.0 мянган төгрөгийн зээл авч, цагаан тоосгоны үйлдвэрийн технологийг хөнгөн бетон үйлдвэрлэх технологт шилжүүлж, шугамыг ашиглалтанд оруулсан.
	Өдөрт 130м3 хөнгөн бетон үйлдвэрлэх хүчин чадалтай болсон.
2008 оны 3 – 7 сард	Зоос банктай 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн гэрээ байгуулж, 8 тоот гэрээгээр 1,041,240.5 мянган төгрөг, 16 тоот гэрээгээр 200 000.0 мянган төгрөгийг тус тус зээлж аван шохойн үйлдвэрлэлийг сэргээж, өргөтгөлийн төслийг хэрэгжүүлж эхэлснээр 80 хүртлэх хувийн идэвхжилтэй, сайн чанарын цэвэр шохойг үйлдвэрлэж эхэлсэн.
	Дээрх арга хэмжээний үр дүнд 2008 онд 20 мянган м3 хөнгөн бетон, 6000 тн шохой үйлдвэрлэж чадсан байна.
	Эдийн засгийн хямралын улмаас банкны үйл ажиллагаа доголдон, зээл олголтыг зогсоосноор төсөл бүрэн хэрэгжих бололцоогүй болсон.
2009	Эдийн засгийн хямрал барилгын салбарыг хөрөнгө мөнгөний хомсдолд оруулсан нь хөнгөн бетоны үйлдвэрлэл болон борлуулалтыг хязгаарласан. Тус онд 18 мянган м3 хөнгөн бетон, 12 мянган тонн шохой үйлдвэрлэж борлуулсан.
2010	Барилгын салбарын хямрал үргэлжилсэнээр хөнгөн бетоны үйлдвэрлэл 12 мянган тонн руу буурсан билээ. Харин уул уурхай салбарын өсөлт гарсан нь таатай байдлыг бий болгосон бөгөөд шохойн хэрэглээ нэмэгдэж 16 мянган тонн хүртэл өссөн юм. Гэвч энэ хугацаанд үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт 30 хүрэхгүй хувьтай байсан нь ашиггүй ажиллах гол үндэслэл болсон болно.
	Банкны зээлийн санхүүжилт зогссоноос үүдэн шохойн үйлдвэрийн өргөтгөлийн төсөл хэрэгжиж чадаагүйн улмаас эрэлт нь улам нэмэгдсээр буй шохойн зах зээлийг хангах бололцоог хаасан. Мөн зээл төлөх хугацаа дууссан нь санхүүгийн хүндрэлд

оруулсан.

Эдгээр хүндрэлийг компанийн дотоод санхүүгийн эх үүсвэрээр даван туулах боломж хязгаарлагдмал тул хамгийн оновчтой хэлбэр болох нэмэлт хувьцаа гарган санхүүжилт татаж, шохойн үйлдвэрлэлийг өргөтгөн технологийг сайжруулж, шохойн зах зээлийн бодит өсөлтийг ашиглах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.

Дээрх шийдвэрийг хэрэгжүүлснээр компанийн засаглал сайжирч, зах зээлийн бодит үнэлгээнд хүрч, нээлттэй идэвхтэй үйл ажиллагаатай хувьцаат компани болно.

2011	Эдийн засаг сэргэж ялангуяа барилга, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт эрс өсч байгаа нь цаашид үйлдвэрлэлээ үр ашигтай, тогтвортой хөтлөн явуулж, зах зээлд эзлэх байр сууриа бататган нэмэгдүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байна.
------	--

Компанийн ойрын зорилго

Компанийн ойрын зорилго нь орчин үеийн техник, технологиор өндөр чанартай, өртөг хямд, байгаль экологид хоргүй, хэрэглэгчдийн хэрэгцээ, барилгын материалын олон улсын стандартад нийцсэн шохой, хөнгөн бетон үйлдвэрлэж зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх явдал юм.


1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (ХНХ) юм. ХНХ-аас төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), хянан шалгах зөвлөл (ХШЗ) тус тус сонгон, ТУЗ нь гүйцэтгэх захирлыг сонгон ажилладаг.

Хувьцаа эзэмшигчдийн тоо




Хувьцаа эзэмшигчдийн бүтэц (хувиар)



Зураг 2 Хувьцаа эзэмшигчдийн тоо, бүтэц

Бүтэц зохион байгуулалт



Зураг 3 Бүтэц зохион байгуулалт

Бодлого төлөвлөлтийн дэд захирал нь хүний нөөц, бодлого төлөвлөлт, харилцагчидтай холбоотой үйл ажиллагааг шууд хамаарч ажилладаг. Бодлого төлөвлөлтийн хэлтэст ерөнхий менежер, маркетингийн менежер, борлуулалтын менежер, Улаанбаатар салбар хариуцсан захирал, механик инженер, хөдөлмөр хамгаалалтын инженер, туслах, тогооч, үйлчлэгч зэрэг хүмүүс хамааран ажилладаг.

Санхүү эрхэлсэн дэд захирал нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүү, аж ахуйн хэсгийг хариуцдаг бөгөөд уг хэлтэст ерөнхий нягтлан бодогч -1, хяналтын нягтлан бодогч -1, тооцооны нягтлан бодогч-1, нярав-2 ажиллаж байна.

Үйлдвэрлэлийн үндсэн гүйцэтгэлийн хэсэгт хөнгөн бетон болон шохойн үйлдвэр, **үйлдвэрлэлийн туслах хэсгүүд** болон механик цех, цахилгаан сантехникийн хэсэг, чанар хяналтын хэсгүүд хамаардаг болно.

Хөнгөн бетоны үйлдвэр нь үйлдвэрийн I, II гэсэн хэсэгтэйгээр ажилладаг бол шохой боловсруулах үйлдвэрт уулын хэсэг, зуухан цех хамаардаг юм. Механик цех нь засварын бригад, авто засварын хэсэг гэсэн бүрэлдэхүүнтэй, цахилгаан сантехникийн хэсэг нь сантехник, цахилгаанаа тус тусдаа хариуцсан хэсгүүдтэй, чанар хяналтын хэсэг нь лаборантын болон чанар шалгагчаас бүрдэнэ.

Хөнгөн бетон	Шохойн цех	Механик цех
1. Ээлжийн ахлах зуурагч 2	1. Зуухны ахлах оператор 3	1. Токарьчин 1
2. Туслах зуурагч 2	2. Зуухны туслах оператор 9	2. Гагнуурчин 2
3. Хэв өргөгч 2	3. Шохой дамжуулах оператор 3	3. Засварчин 4
4. Хэв тослогч 2	4. Чулуу бутлах оператор 3	4. Сан техникийн слесарь 2
5. Элсний тээрмийн оператор 2	5. Чулуу ялгагч 6	5. Жолооч 6
6. Шохой дамжуулах оператор 2	6. Эксваторчин 1	6. Зуухны мастер 1
7. Элсний оператор 2	7. Тэсэлгээний оператор 1	7. Цахилгааны инженер 1
8. Талбайн дамжуулах оператор 4		
9. Кранист 3		
10. Ачигч 2		
11. Автоклавын ахлах оператор 3		
12. Автоклавын туслах оператор 3		
13. Цахилгаанчин 3		

Хүснэгт 2 Цехүүдийн боловсон хүчин

Үнэт цаас гаргагчийн ажиллах хүчний бүтэц, бүрэлдэхүүн үйлдвэрийг анх ашиглалтад орсон 45 жилийн өмнөөс бүрэлдэн 2-3 үеийн ажилчид ажилладаг. Үйлдвэрийн ашиглалтын явцад залуу боловсон хүчнээр сэлбэгдэн шинэчлэгдэн ажилладаг ба үйлдвэрийн нийт ажилчдын 38,95% нь 35 хүртлэх насны, 31,58% нь 35-45 насны, үлдэх 29,47% нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Мэдлэг боловсролын тухайд нийт 44 албан тушаалын байранд 20-45 насны 95 ажилчид ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн 38% нь дээд, 60% нь дунд мэргэжлийн буюу мэргэжсэн ажилчид, 2% нь 10 жилийн боловсролтой хүмүүс байна.

1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг хуваарилах бодлого

- Компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг өсгөн зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.
- Компанийн ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн батлана.
- Компани тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө танилцуулна.
- Компанийн үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилахдаа бэлэн мөнгө, үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болно.

Хуваарилах ашгийн хэмжээг тодорхойлох

- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.
- Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна. Энэхүү дүн нь компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 20%-иас доошгүй хэмжээтэй байна.
- Компанийн тухай хуулийн дагуу ногдол ашиг хуваарилахад дараах нөхцлүүдийг хангасан байна
 - i. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
 - ii. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн дүн давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байна.

Ашиг хуваарилах

- Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Компани хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгөөр ногдол ашиг хуваарилахдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулан нэгдсэн журмаар олгоно.
- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна.

1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН 5-С ДЭЭШ ХУВИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

№	Үнэт цаас эзэмшигч	Эрхэлдэг ажил, байршил	Хаяг	Эзэмшиж буй хувь
1	Цэрэннадмид Содбилэг	“Силикат” ХК-ийн гүйцэтгэх захирал	УБ, ЧД, 8-р хороо, 31-49 тоот	24,95%
3	Содбилэг Золбоотөгс	Сурагч	УБ, ЧД, 8-р хороо, 31-49 тоот	21,72%
4	Содбилэг Оджаргал	Сурагч	УБ, ЧД, 8-р хороо, 31-49 тоот	18,93%
2	Дорж Энхболд	“Силикат” ХК-ийн санхүү эрхэлсэн захирал	УБ, БЗД, 4-р хороо, 200-39 тоот	12,77%

3	Володя Мөнхтуяа	“Агч трейд” ХХК-ийн нягтлан	УБ, ЧД, 8-р хороо, 31-49 тоот	12,00%
5	Нямдаш Цогцлон	“Силикат” ХК-ийн Бодлого төлөвлөлт хүний нөөц хариуцсан дэд захирал	Дархан Уул аймаг, 15-р баг 6-р хэсэг 12 тоот	7,50%

Хүснэгт 3 Үнэт цаас эзэмшигчдийн мэдээлэл

1.8 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 81-р зүйл, компанийн дүрмийн 4-р зүйлд зааснаар компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүд, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

№	Овог нэр	Мэргэжил	Албан тушаал	Хувьцаа эзэмшдэг эсэх
1	Даваасүрэн Туул	Хуульч, эрх зүйч	“Силикат”ХК-ийн ТУЗ-ийн дарга	Үгүй
2	Цэрэннадмид Содбилэг	Филисофи	“Силикат” ХК-ийн гүйцэтгэх захирал	24,9%
3	Цэрэннадмид Сэргэлэн	Уулын баяжуулагч	“Силикат” ХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн захирал	2%
4	Цэрэннадмид Болормаа	Нягтлан бодогч	“Силикат” ХК-ийн нягтлан бодогч	Үгүй
5	Дорж Энхболд	Бүрэн дунд	“Силикат” ХК-ийн борлуулалт хариуцсан менежер	12,77%
6	Володя Мөнхтуяа	Эдийн засагч	“Агч трейд” ХХК-ийн нягтлан бодогч	12,00%
7	Нямдаш Цогцлон	Хуульч	“Силикат” ХК-ийн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал	7,5%
8	Мягмарсүрэн Наранзул	Барилгын материалын технологич	“Силикат” ХК-ийн технологич	Үгүй
9	Бямба Сэр-Од	Барилгын материалын технологич	“Силикат” ХК-ийн технологич инженер	Үгүй

Хүснэгт 4 ТУЗ-ын гишүүдийн мэдээлэл

Гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүд, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүдийн мэдээлэл

Гүйцэтгэх захирал	Цэрэннадмидын Содбилэг нь 1968 оны 01 дүгээр сарын 16-нд Өвөрхангай аймгийн төвд төрсөн. 1976-1986 онд ерөнхий боловсролын сургуульд, 1993-1997 онд Тэнгэр дээд сургуулийн Философи социологийн ангийг социологич мэргэжлээр төгссөн. 1998-2007 онд Монгол газар компанид Дэд захирлаар, 2007 оноос Силикат ХК-д гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.
Ерөнхий инженер	Галдаабаатар овогтой Ганболд нь 1970 оны 11 дүгээр сарын 25-нд Дархан хотод төрсөн. 1978-1988 онуудад ерөнхий боловсролын сургуульд суралцсан. 1994 онд Дархан хотын ТИС-ийн барилгын материал технологи инженерээр төгссөн. 2009 онд Монгол Улсын мэргэшсэн инженерийн болзлыг хангасан.
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал	Жалбуу овогтой Ганболд нь 1965 оны 6 дугаар сарын 17-нд Дорноговь аймгийн Сайншанд суманд төрсөн. 1988 онд Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн их сургуулийг Агро-химич мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд 2000 онд ОХУ-ийн Екатеринбург хотын Уралын их сургуулийг Бизнесийн удирдлагын чиглэлээр төгсчээ. Тэрбээр 1988-1993 онд Ургамал Газар Тариалангын Эрдэм шинжилгээний хүрээлэнд, 2001-2009 онуудад “Агч Формула” ХХК-нд захиралаар ажиллаж байсан бөгөөд 2009 оноос эхлэн “Силикат” ХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захиралаар ажиллаж байна.
Ерөнхий нягтлан бодогч	<p>Дэжмаа овогтой Уранчимэг нь 1958 оны 04 дүгээр сарын 10-нд Завхан аймгийн Алдархаан суманд төрсөн. 1965-1975 онд Завхан аймгийн 10 жилийн сургуулийг, 1977 онд Худалдааны техникумын Нягтлан бодогч-эдийн засагч мэргэжлээр, 1981 онд МУИС-ийн ЭЗ-ийн факультетийг нягтлан бодогч-эдийн засагч мэргэжлээр, 1998 онд Удирдлагын академийн эдийн засгийн бакалавр мэргэжлээр тус тус төгссөн. Монгол Улсын хугацаагүй эрхт мэргэшсэн нягтлан бодогч, Монгол Улсын аудиторын болзлыг хангасан.</p> <ul style="list-style-type: none"> - 1977-1986 онд Завхан аймгийн Бөөний баазад ахлах нягтлан бодогч - 1986-1991 онд Завхан аймгийн Хот тохижилтын газрын ерөнхий нягтлан бодогч - 1991-2003 онд Завхан аймгийн Ус сувгын газрын ерөнхий нягтлан бодогч - 2003-2008 онд УБ аудит корпорацид аудит - 2008 оноос Силикат ХК-д ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байна
Механик	Сайнбаяр овогтой Баярсайхан нь 1970 онд Дархан хотод төрсөн. 1978-1988 онд Булган аймгийн 10 жилийн

инженер	сургуулийг, 1988-1993 онд Беларусь улсын Мотилон хотод Барилгын техникумын сантехникийн техникч мэргэжлээр, 1993-1997 онд ШУТИС-ийн Дархан дахь салбарын БМУТТ-ийн инженер мэргэжлээр тус тус төгссөн. 1997-2009 онуудад УБ хотын “Хөнгөн бетон” ХК-ны үйлдвэрт механик инженерээр ажилласан. 2011 оноос “Силикат” ХК-д механик инженерээр ажиллаж байна. 2009 онд Монгол Улсын мэргэшсэн инженерийн цол горилсон.
Хөдөлмөр хамгаалалын инженер	Сарынд овогтой Асылхан 1945 онд Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд төрсөн. 1958-1968 онд Баян-Өлгий аймгийн 10 жилийн сургуулийг, 1968-1973 онд ЗХУ-ын Свердловск хотын Политехникийн дээд сургуулийг дулааны инженер мэргэжлээр төгссөн. 1973-2005 онд Дархан хотын Дулааны Цахилгаан станцад дулааны инженер, зуухны засварын инженер, ИТАлбаны ахлах инженер, 2005-2007 онд Ноёд группын Дулааны инженерээр, 2007 оноос “Силикат” ХК-д дулааны инженер, хөдөлмөр хамгаалалын инженерээр тус тус ажилласан. 2006 онд Монгол Улсын мэргэшсэн инженерийн болзлыг хангасан.

Хүснэгт 5 Удирдлагын багийн гишүүд

1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИ, ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААРХ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн олон нийтэд гаргасан нийт хувьцааны хяналтын багцыг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт эзэмшигч нь тус компанийн гүйцэтгэх захирал Ц.Содбилэг юм.

Компанийн хяналтын багц эзэмшигчийн өр төлбөрийн талаарх 2010 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба”-ны тодорхойлолт, 2010 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Монгол банкны зээлийн мэдээллийн сан”-гийн тодорхойлолтоор хяналтын багц эзэмшигч нь хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

1.10 КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус үйлдвэр нь 2006 оноос зах зээлийн эрэлт хэрэгцээ, үр өгөөжийг судалсны үндсэн дээр силикат тоосго үйлдвэрлэх шугамыг хөнгөн бетон үйлдвэрлэх шугамд шилжүүлэх ажлыг эхлүүлж тухайн оныхоо 2 сарын 25-нд ашиглалтанд оруулсан. Хөнгөн блок нь (360x180x600) ба (360x240x600) гэсэн хэмжээтэйгээр хоногт 130 м3, жилд 40000 м3 хөнгөн бетон үйлдвэрлэх хүчин чадалтай.

Мөн 2008 онд шохойн үйлдвэртээ технологийн нэмэлт шинэчлэлт хийснээр 80 хүртэлх хувийн идэвхжил бүхий 80-180 мм бүхэл, 0-30 мм буталсан хагас нунтаг, 0,063-0,08 мм тээрэмдсэн нунтаг шохой гэсэн ангиллаар сайн чанарын цэвэр



шохойг үйлдвэрлэж эхэлсэн. Шохой нь MNS-347-99, MNS-347-2002 тоот Улсын стандарттай.

Тус үйлдвэр нь хөнгөн бетон блокны үйлдэрлэл, шохойн үйлдвэрлэл, элс болон шохойн чулуун олборлолт гэсэн 3 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, дараахь нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

Бүтээгдэхүүн	Стандарт	Хэмжээ	Хүчин чадал
Хөнгөн бетон блок		360x180x600 360x240x600	Жилд 40 мянган м ³ / хоногт 135м ³
Шохой	MNS-347-99 MNS-347-2002	70-80 орчим хувийн идэвхжил бүхий бүхэл (10-80мм) болон нунтаг шохой	Хоногт 30т/ жилд 10 мянган тонн
Шохойн чулуу	MNS-963-91		Цагт 40тн
Элс		SiO ₂	

Хүснэгт 6 Компанийн үйлдвэрлэл

Шохойг өөрийн хөнгөн бетоны үйлдвэрлэлд түүхий эдийн зориулалтаар ашиглахаас гадна шууд хэрэглэгчид нийлүүлж байна.



Шохойн үйлдвэрлэлийн технологийн горим

Шохойн чулууг технологийн дагуу олборлон, 15-20тн даацтай автомашинаар 600мм х 600мм х 600мм-ээс бага ширхэглэлтэйгээр тээвэрлэн авчирч хацарт бутлуураар анхан шатны бутлалт хийж, шигшүүрээр ялган технологт тохирох фракцтай (Ø60мм -930мм) чулууг шохойн зууханд шатааж, технологт тохирохгүй жижиг фракцтай чулуу болох 15-45мм ширхэгтэйг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт, 5-15мм ширхэгтэйг барилгын компаниудад дайрганы зориулалтаар, 0-25мм ширхэгтэйг Эрэл цементийн үйлдвэрт тус тус хөнгөлөлтэй үнээр борлуулдаг. Эдгээр жижиг фракцын чулууг бүрэн (10-60мм) ашиглаж болох технолог нэвтрүүлэх шаардлага тавигдаж байгаа. Шохойн чулууг шохой шатаах 4 зууханд ачаалж, 1200⁰С температурт шатааж ($\text{CaCO}_3 \rightarrow \text{CaO} + \text{CO}_2\uparrow$) шохой гарган авна. Зуухнаас гарсан шохойг шигшүүрээр бүхэл нунтаг болгон ялгаж Бороо Гоулд, Арьс ширний үйлдвэрүүд, хөнгөн бетоны үйлдвэрүүдэд хувиарилж борлуулна. Шохойн чанарт нөлөөлөх гол хүчин зүйл бол шохойн чулууны

химийн найрлага юм. Шохойн чулууны найрлага дахь CaCO₃ – 90%-ээс доошгүй, MgO–3%-аас ихгүй, бусад агуулга 10%-аас ихгүй байх шаардлагатай.

Уулын баяжуулах үйлдвэрийн хөвүүлэн баяжуулах процессыг идэвхжүүлэхийн тулд уусмал дахь рН-ийн түвшинг өсгөж урвал явагдах орчинг тохируулдаг үндсэн түүхий эд нь шохой юм.

Компаний бүтээгдэхүүний чанар, үзүүлэлт, өртөг болон үнэнд нөлөөлөх зүйлс нь мэдээж дэд бүтэц, түүхий эд материал байдаг.

Түүхий эд материалын хувьд авч үзвэл:

Шохой нь өөрөө бэлэн бүтээгдэхүүн болохоос гадна хөнгөн бетоны гол түүхий эд болдог. Шохойн болон хөнгөн бетоны үндсэн түүхий эд материал нь цахиурлаг элс, шохойн чулуу, нүүрс, өндөр даралтын уур байдаг.

Шохойн чулуу - Дархан-Уул аймгийн шохойн чулууны 5 дугаар ордоос өрөмдлөг тэсэлгээний аргаар олборлон авч ашиглана.

Компани нь одоогийн байдлаар шохойн үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд “СиБиЗи” ХХК, “Идэр хайрхан” ХХК-тай шохойн чулуу худалдан авах гэрээ байгуулан ажиллаж байгаа. Шохой нийлүүлэгч компаниуд нь өөрсдийн ордоос чулуу бэлдэн нийлүүлдэг.

Дархан-5 ордын дэлгэрэнгүй мэдээлэл:

Ордын байршил: Дархан Уул аймгийн нутагт Дархан хотоос зүүн ургаш 8 км, “Силикат” ХК-ийн үйлдвэрээс 4 км зайд оршино

Ордын газар зүйн байршлын солбилцол нь: 106° 5`д.У ; 49° 45`х.Ө

Ашиглалтын тусгай зөвшөөрөл: 14949А

Нийт тайлбайн хэмжээ: 24,9 га талбай

Хайгуул хийж нөөц тогтоосон талбайн хэмжээ: 4,9 га талбай

Тогтоогдсон нөөцийн хэмжээ: 420,7 мянган тонн

Геологийн судалгааны түүх: 1995 онд “Их үүсгэл” ХК-ийн ерөнхий геологич С.Должин, инженер Ц.Еочинхүү нарын удирдлагаар Дарханы шохойн чулууны 5-р ордод урьдчилсан хайгуулын ажил хийж шохойн чулууны нөөцийг үйлдвэрийн зэргээр үнэлсэн.

Ордын шохойн чулууны хими эрдсийн найрлага

Дээжийн дугаар	Карбонатад хамаарах исэлийн агуулга, %				Үндсэн эрдсийн агуулга
	CaO	MgO	ШГХ	Бусад хольц	
Tso-1	53,48	0,38	42,55	3,59	CaCO ₃ -95,50
Tso-2	54,04	0,19	42,79	2,98	CaCO ₃ -96,50
Tso-3	53,20	0,19	41,97	4,64	CaCO ₃ -96,00
Tso-4	53,20	0,58	42,19	4,03	CaCO ₃ -95,00

Хүснэгт 7 Ашиглахаар төлөвлөж буй шохойн чулууны ордын шохойн чулууны эрдэсийн найрлага

Дээж авалтын тэмдэглэл Tso өрмийн дугаар.

Дээрх ордын хими эрдсийн найрлага нь уул уурхайн салбарт баяжуулах үйлдвэрүүдийн хүдэр баяжуулах технологийн орчин тохируулагч гол түүхий эдийн болзлыг бүрэн хангаж байгаа.

Ордын техник эдийн засгийн үндэслэл, орд ашиглалт

Хөдөө аж ахуй үйлдвэрийн яамны геологи уул, уурхайн газрын дэргэдэх ШУТЗ-ийн 1996 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 189 тоот хурлын протоколоор шохойн чулууны 5-р ордын (“Силикат” ХК-ийн 14949А тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн 24,9 га талбайд хамаарах) нөөцийг С1 зэргээр 1205.5 мянга.тн-оор тогтоосон.

Ордын техник эдийн засгийн үндэслэлийг 2010 онд Монгол Улсын зөвлөх инженер Ц.Билэгтбаяраар ахлуулсан “Эвсэг Монгол” ХХК-ийн уул уурхайн инженерийн баг гүйцэтгэсэн. Тус техник эдийн засгийн үндэслэлээр ордын 1/5-д буюу 4,9 га талбайд тодорхойлсон 420,7 мянган тонн нөөцийг жилд 86 мянган тонн шохойн чулуу олборлолт хийн 4,9 жил ашиглахаар тооцоолсон. Шохойн ордын үлдсэн 4/5 буюу 20 га талбайн нөөцийг дахин шинэчлэн тогтоон дараагийн жилүүдээс шохойн чулуун олборлолтыг хийнэ.

Байгаль орчны нөхөн сэргээлт

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газар нь гүний ангилалд хамаарагдах бөгөөд нөхөн сэргээлт хийгдэнэ. Хөрс хуулалтын ажлын явцад гарах үржил шимт хөрсийг ил уурхайн урд талд овоолго үүсгэн овоолно. 2,6 га талбай шинээр эвдрэлд орох ба эвдрэлд орсон талбайг нөхөн сэргээнэ. Ашиглалтын 1, 2, 3, 4-р жилийн хөрсийг гадаад овоолгоор нөхөн дүүргэлт хийж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлууд хийнэ.

Хувьцаа гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн 17,9 хувь нь уулын ажлын техникийн бааз суурийг шинээр байгуулахад зарцуулагдана. Ордын хөрс хуулалт дунджаар 2.6-3.0 м цаашид уг ордод нарийвчилсан хайгуул хийх шаардлагатай.

Цахиурлаг элс – Компанийн эзэмшиж буй ашигт малтмал ашиглах лицензийн 3998Х тоот гэрчилгээ бүхий Хараа голын баруун эрэгт орших “Сайхан”-ы ордоос 9 км асфальтан замаар автомашинаар тээвэрлэн хангах ба энэхүү элс нь гүний усанд автаагүй тул тааламжтай нөхцөлтэй, ОСТ 21-1-72-аар Автоклавын хөнгөн бетон ба силикат тоосгоны стандартад тохирсон, хайгуулын үеийн нөөц = А+В+С1 блок = 5,209.9 мянган м³. Өнөөдрийн хүчин чадлаар ажиллахад 60 жилийн турш хангахаар тогтоогдсон.

Чулуун нүүрс-ийг Дархан-Уул аймгаас 75 км зайд орших Шарын голын уурхайгаас төмөр замаар гэрээний үндсэн дээр тээвэрлэн хангадаг.

Өндөр даралтын уур-ийг Үйлдвэрээс 400м-ийн зайд орших Дархан-Уул аймгийн дулааны цахилгаан станцаас уурын шугамаар гэрээний үндсэн дээр авч хангана.

Түүхий эд материалыг шаардагдах тоо хэмжээгээр ашиглалтын лицензийн гэрчилгээ, аж ахуйн гэрээний үндсэн дээр ашиглана. Ил уурхайд ашиглалт эрхлэн явуулах хүндрэл, саад бэрхшээл байхгүй бөгөөд уулын болон авто тээврийн машин техникт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд парк шинэчлэлт хийгдээгүйн улмаас хуучирч элэгдэн ашиглалтын шаардлага хангахгүйд хүрсэн байдлыг харгалзан паркийн зохих хувийг шинэчлэх арга хэмжээ авахаар ажиллаж байгаа.

Дэд бүтцийн хувьд авч үзвэл:

Тус үйлдвэр нь Дархан хотын үйлдвэрийн дүүрэгт байрладаг, дэд бүтцийн хувьд бүрэн бие даасан байдалтай. Өөрийн бүтээгдэхүүнийг Дархан уул аймаг төдийгүй Булган, Сэлэнгэ, Орхон, Алтанбулаг, Улаанбаатар, Сайншанд, Замын Үүдийн чөлөөт бүс зэрэг аймаг хотуудад асфальтан болон төмөр замаар тээвэрлэн хүргэх нөхцөл бүрдсэн, газар зүйн байршлын хувьд ашигтай зангилаа байрлалд оршдог байна. Тухайлбал:

- ✓ Өөрийн эзэмшлийн 1км төмөр замтай бөгөөд Дархан-2 өртөөтэй холбогдсон.
- ✓ Асфальтан замаар Дархан, Улаанбаатар болон Мянганы замтай холбогдсон.
- ✓ Өндөр даралт (12-15ат)-ын уурын ф150 мм шугамаар ДЦС-тай холбогдсон.
- ✓ Үйлдвэрийн дүүргийн цэвэр, бохир усны шугамд холбогдсон.
- ✓ Утсан харилцааны хүрэлцэх тооны дугаараар хангагдсан. Эдгээр шугамын багтаамж даац хүрэлцэх хэмжээний нөөцтэй тавигдсан. Утас, факс, интернэт гэх мэт харилцаа холбооны үйлчилгээнд бүрэн холбогдсон

Үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэд бүтцийн нэмэгдэл эх үүсвэр шаардлагагүй.


Сүүлийн 3 жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ

Бүтээгдэхүүн	2008	2009	2010
Хөнгөн бетон/м3	19 880,00	9 722,10	9 998,80
Шохой/тн	5 316,50	9 075,10	7 171,50

Хүснэгт 8 Сүүлийн 3 жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ

Өнгөрсөн 3 жилийн дунджаар манай компани хөнгөн бетон үйлдвэрлэлийн хүчин чадлынхаа 30 хүрэхгүй хувийг ашиглаж байсан нь үйлдвэрлэлийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсан.

Үйлдвэрийн хүчин чадал ашиглалт



Зураг 4 Үйлдвэрийн хүчин чадал ашиглалт

2008 оноос барилгын салбарын бүтээн байгуулалтын хэмжээ буурч, уул уурхайн салбар эрчимтэй өсөн нэмэгдсэнээр компани нь шохойн үйлдвэрлэлд түлхүү анхаарч ажилласан.



Шохой үйлдвэрлэл

Орлого зарлагын бүтэц

ҮЗҮҮЛЭЛТ	2007 он	2008 он	2009 он	2010 он
	хувь	хувь	хувь	хувь
Борлуулалтын орлого	100,00	100,00	100,00	100,00
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	94,01	49,85	82,40	81,89
Нийт ашиг	5,99	50,15	17,60	18,11
Үйл ажиллагааны зардал	19,14	17,48	6,76	9,44
Үйл ажиллаганы ашиг	-13,15	32,68	10,84	8,67
Зээлийн хүүгийн зардал	23,42	29,39	11,75	5,10
Татварын өмнөх ашиг	- 36,57	3,28	- 0,91	3,57
Орлогын татвар	-	0,03	-	0,36
Татварын дараах цэвэр ашиг	- 67,86	0,31	- 6,05	3,21

Хүснэгт 9 Орлого зарлагын бүтэц

1.11 СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН БОЛОН ҮНЭТ ЦААС ГАРГАХААР ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ ГАРГАХЫН ӨМНӨХ УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД /Мянган төгрөг/

БАЛАНС

ҮЗҮҮЛЭЛТ	2007 он	2008 он	2009 он	2010 он
Эргэлтийн Хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	685.0	245.0	705.0	4 420.0
Дансны авлага	61 327.0	73 279.0	29 867.0	24 666.0
Бусад авлага	31 521.0			
Бараа материал	154 571.0	910 760.0	610 505.0	873 129.0
Урьдчилж төлсөн зардал		90 000.0	90 000.0	
Эргэлтийн хөрөнгийн дүн	248 103.0	1 074 284.0	731 077.0	902 215.0
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	761 762.0	1 027 771.0	1 545 250.0	4 317 238.0
Хуримтлагдсан элэгдэл	-150 718.0	-210 777.0	-400 485.0	-134 480.0
Бусад үндсэн хөрөнгө		3 379.0	3 379.0	93 210.0
Хуримтлагдсан элэгдэл				-1 350.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	611 044.0	820 373.0	1 148 143.0	4 274 617.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	859 147.0	1 894 657.0	1 879 220.0	5 176 833.0
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	133 219.0	97 696.0	149 280.0	286 727.0
Цалингийн өглөг	6 211.0	12 604.0	-	2 294.0
Орлогын татварын өглөг		221.0	221.0	4 572.0
ХАОАТ-н өглөг	8 885.0	26 996.0	21 238.0	13 122.0
НӨАТ-н өглөг	9 475.0	10 735.0	-	8 668.0
Бусад татварын өглөг	8 357.0	1 449.0	449.0	9 995.0
ЭМНД-ийн шимтгэлийн өглөг	25 172.0	17 615.0	-	-
Банкны богино хугацаат зээл	441 115.0	1 501 526.0	1 491 526.0	1 454 250.0
Бусад өглөг	114 510.0	111 592.0	110 817.0	374 840.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	746 944.0	1 780 435.0	1 773 531.0	2 154 469.0
Эзэмшигчдийн өмч				
Хувьцаат капиталын дүн	17 013.0	17 013.0	17 013.0	17 013.0
Дахин үнэлгээний нөөц	430 305.0	430 305.0	430 305.0	3 595 288.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-335 114.0	-333 095.0	-341 629.0	-589 936.0
Тайлангийн үеийн	-198 513.0	2 019.0	-8 534.0	39 198.0
Өмнөх үеийн	-136 601.0	-335 114.0	-333 095.0	-629 134.0
Эзэмшигчдийн өмчийн дүн	112 203.0	114 222.0	105 688.0	3 022 364.0
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	859 147.0	1 894 657.0	1 879 220.0	5 176 833.0

Хүснэгт 10 Баланс

ОРЛОГЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2007 он	2008 он	2009 он	2010
-----------------	----------------	----------------	----------------	-------------

Үндсэн үйл ажиллагааны орлого				
Борлуулалтын орлого	292 512.0	652 468.0	1 010 918.0	1 220 653.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(274 998).0	(325 244.0)	(832 694.0)	(999 593.0)
Нийт ашиг (алдагдал)	17 513.0	327 224.0	178 224.0	221 059.0
Үйл ажиллагааны зардал				
Үндсэн болон нэмэгдэл цалин зардал	28 871.0	45 797.0	32 033.0	19 297.0
Нийгмийн даатгалын зардал	5 774.0	2 764.0	3 096.0	2 277.0
Засвар үйлчилгээний зардал	2 513.0	72.0	-	8 984.0
Ашиглалтын зардал		11 687.0	150.0	6 739.0
Түрээсийн зардал		1 673.0	776.0	244.0
Албан томилолтын зардал	2 780.0	20 060.0	833.0	1 721.0
Тээврийн зардал		1 100.0	55.0	1 000.0
Түүхий эд материалын зардал		4 305.0	181.0	1 788.0
Элэгдлийн зардал		54.0	13 291.0	18 194.0
Зар сурталчилгааны зардал	556.0	2 750.0	2 770.0	3 104.0
Шуудан, холбооны зардал	7 761.0	1 139.0	1 321.0	4 449.0
Шатахууны зардал	4 628.0	3 952.0	7 973.0	25 072.0
Шагнал, урамшуулалын зардал, бичиг хэрэг	1 412.0	525.0		1 322.0
Зээлийн хүүгийн зардал	68 500.0	191 771.0	118 828.0	62 241.0
Бусад зардал	1 680.0	18 146.0	5 888.0	21 076.0
Үйл ажиллагааны зардлын дүн	124 475.0	305 793.0	187 195.0	177 506.0
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(106 962.0)	21 431.0	(8 970.0)	43 553.0
Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг (алдагдал)	(91 551.0)		633.0	-
Бусад		(19 187.0)	(1 069.0)	
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	(91 551.0)	(19 187.0)	-436.0	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(198 513.0)	2 244.0	(9 406.0)	43 553.0
Орлогын татварын зардал		224.0		4 355.0
ТАТВАР ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	(198 513.0)	2 019.0	(61 128.0)	39 198.0

Хүснэгт 11 Орлогын тайлан

Нягтлан бодох бүртгэл, аудит баталгаажуулалт, хөрөнгийн үнэлгээний “Сүлд Аудит” ХХК нь Үнэт цаас гаргагч компанийн 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2010 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн үлдэгдэл тэнцэл, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, тэмдэглэл, тодруулгад хараат бус аудиторын тайлан гарган баталгаажуулсан. Тус компанийн дүгнэлтээр:

2010 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх “Силикат” ХК-ийн санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээгээр Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, аж ахуйн нэгж

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэл хөтлөх болон санхүүгийн тайлан бэлдэх заавар, журмын дагуу илэрхийлсэн байна.

1.12 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ, ХУУЛЬ ЗҮЙН ХАРААТ БУС ДҮГНЭЛТ

Компани нь олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох худалдах журам”-д заасны дагуу 2010 оны 07 дугаар сарын 18-ны өдөр “Монгол Өмгөөлөгч” хууль зүйн фирмтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажилласан. Гэрээний дагуу хуульчид холбогдох материалуудтай танилцсаны үндсэн дээр дараах чиглэлээр 2010 оны 12-р сарын 22-ны өдрийн №154 тоот албан тоотын хавсралтаар хараат бус дүгнэлт гаргасан. Хуулийн компанийн дэлгэрэнгүй дүгнэлт хавсралтад тусгагдсан.

- Дүрэм, журам, бусад этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл нь хууль тогтоомж, компанийн засаглалын кодекст нийцэж байгаа эсэх,
- Үйл ажиллагааны гол үндэслэл болсон тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах зэргээр үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болох нөхцөл байдлын талаар

Хуулийн компанийн дүгнэлтээр

Дүрэм, журам, гэрээ, хэлцэл нь үнэт цаас гаргагчийн болон хөрөнгө оруулагчдын ашиг сонирхол, үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, хорооноос тогтоосон журмуудад нийцэж байгаа эсэх талаар:

“Силикат” ХК-ийн дүрэм, үйл ажиллагааны журмууд нь компанийн хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцсэн, хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн хангаж боловсруулагдсан төдийгүй Үнэт цаасны тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцэж байна. Харин 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 8 тоот зээлийн гэрээний зээлдүүлэгч тал болох Зоос банк нь зээлийг хуваарийн дагуу олгох үүргээ биелүүлээгүй байдлаас шалтгаалж компанийн төлөвлөсөн үйл ажиллагааг алдагдуулсан, бусадтай байгуулсан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тасалдуулахад хүргэн, санхүүгийн хүндрэлд оруулсан зэргээс шалтгаалж хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Үйл ажиллагааны гол үндэслэл болсон тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах зэргээр үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болох нөхцөл байдлын талаар:

“Силикат” ХК нь одоогоор үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох элс, хайрга, шохойн чулууны орд бүхий талбайд хайгуул хийх, ашиглалт явуулах эрхийг олгосон тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг. Дээрх 2 тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу эзэмшиж байгаа бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаж байгаа тул тусгай зөвшөөрөл цуцлагдах шалтгаан байхгүй байна.

Сүүлийн 3 жилд хийсэн хэлцлийн дотор их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх талаар:

“Силикат” ХК-иас “Зоос банк”-тай байгуулсан 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 8 тоот Зээлийн гэрээ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байна. Учир нь уг гэрээ байгуулагдах үед компанийн балансын актив 1.133.516.022 /нэг тэрбум нэг зуун гучин гурван сая таван зуун арван зургаан мянга хорин хоёр/ төгрөг байжээ. /компанийн 2008 оны 1-р улирлын санхүүгийн тайланд үндэслэв/ Уг гэрээг байгуулахад компанийн ТУЗ-ийн хурлын 2007 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот тогтоолыг үндэслэсэн байна. Уг тогтоолоор гэрээ байгуулах эрхийг гүйцэтгэх захирал Ц.Содбилэгт олгожээ. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, компанийн дүрмийн 8.1-д заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх эрх олгох эрхийг компанийн ТУЗ-д хамааруулсан байна. ТУЗ-ийн тогтоол нь компанийн дүрэмд заасан шаардлагыг хангаж байна.

Компаниас сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 86 дугаар зүйлд заасан сонирхлын зөрчил бүхий этгээдтэй гэрээ хэлцэл байгуулаагүй байна /компаниас гаргаж өгсөн сүүлийн 3 жилд бусад этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл болон гүйцэтгэх захирал, хувь нийлүүлэгчдийн хурлын даргын тайлбарыг үндэслэв/.

Компанийн тухай хуулийн 84-р зүйлд заасны дагуу хэлцэл хийхийн өмнөх балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцлийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга:

№	Активын дүнд эзлэх хувь	Гэрээний агуулга	Гэрээ байгуулсан огноо	Эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр
1.	51% /2007 оны 3-р улирлын санхүүгийн тайланд эзлэх дүнгээр/	Зоос банкттай байгуулсан зээлийн гэрээ	2007 оны 07 дугаар сарын 02	ТУЗ-ийн 2007/02/26-ны өдрийн 03 тоот тогтоол
2.	106% /2008 оны 1-р улирлын санхүүгийн тайланд эзлэх дүнгээр/	Зоос банкттай байгуулсан зээлийн гэрээ	2008 оны 03 дугаар сарын 12	ТУЗ-ийн 2007/02/26-ны өдрийн 03 тоот тогтоол
3.	11% /2008 оны 3-р улирлын санхүүгийн тайланд эзлэх дүнгээр/	Зоос банкттай байгуулсан зээлийн гэрээ	2008 оны 07 дугаар сарын 18	ТУЗ-ийн 2007/02/26-ны өдрийн 03 тоот тогтоол

Хүснэгт 12 Компанийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл

“Силикат” ХК-иас “Зоос банк”-тай байгуулсан 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 8 тоот Зээлийн гэрээ, 2008 оны 07 сарын 18-ны өдөр байгуулсан Зээлийн гэрээ нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлд заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байна.

Гэрээ байгуулагдсан: Уг гэрээг байгуулахад компанийн ТУЗ-ийн хурлын 2007 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот тогтоолыг үндэслэсэн байна. Уг тогтоолоор гэрээ байгуулах эрхийг гүйцэтгэх захирал Ц.Содбилэгт олгожээ. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, компанийн дүрмийн 8.1-д заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх эрх олгох эрхийг компанийн ТУЗ-д хамааруулсан байна. Иймд ТУЗ-ийн тогтоолоор гүйцэтгэх захиралд эрх олгон гэрээ байгуулсан нь хууль, дүрэмд нийцэж байна.

Гэрээ нь сонирхолын зөрчилтэй эсэх: Компанийн тухай хуулийн 86 дугаар зүйлд заасны дагуу Зоос банк нь “Силикат” ХК-тай сонирхлын зөрчил бүхий гэрээ хийх этгээдэд хамаарахгүй тул тус гэрээ нь сонирхлын зөрчилгүй хэлцэлд тооцогдоно.

Гэрээ хүчинтэй эсэх: Компанийн хөрөнгө оруулалт, эргэлтийн үйл ажиллагааны санхүүжилтэнд зориулан Зоос банкнаас авсан зээлийн гэрээнүүд нь бүгд хүчин төгөлдөр байгаа.

Гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт:

1. 2007 оны 07 дугаар сарын 02-нд 441 115 000 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн гэрээ байгуулсаны дагуу Зоос банкнаас 2007 оны 07 дугаар сарын 05-аас 2007 оны 12 дугаар сарын 03-ны хооронд нийт 441 115 000 төгрөгийн зээл олголт хийгдсэн. Тус зээлээс 0,2%-ийн эргэн төлөлт хийж 440 282 996 төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй байна.
2. 2008 оны 03 дугаар сарын 12-нд 2 000 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн гэрээ байгуулсаны дагуу Зоос банкнаас 2008 оны 03 дугаар сарын 13-аас 2008 оны 04 дүгээр сарын 24-ны хооронд нийт зээлийн 52% тай тэнцэх дүнгээр буюу 1 041 240 503 төгрөгийн зээл олголт хийгдсэн. Компани нь тус зээлээс 13,6%-ийн эргэн төлөлт хийж 900 000 000 төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй байна.
3. 2008 оны 07 дугаар сарын 18-нд 200 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн гэрээ байгуулсаны дагуу Зоос банкнаас 2008 оны 07 дугаар сарын 28-нд 200 000 000 төгрөгийн зээл олголт хийгдсэн. Компани нь тус зээлээс 43%-ийн эргэн төлөлт хийж 113 966 672 төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Монгол банкнаас зээл олгогч Зоос банкинд 2009 оны 11 дүгээр сарын 20-нд бүрэн эрхт төлөөлөгчөө томилж, 2010 оны 07 дугаар сарын 26-нд “Силикат” ХК-ийн зээлийг шүүхэд шилжүүлснээр зээлийн хүү бодолт албан ёсоор зогссон болно.

1.13 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

Компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 9011119040 улсын бүртгэлийн дугаар, 19 тоот хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ бүхий “Үндэсний Реалти” ХХК-аар хөрөнгийн үнэлгээг 2010 оны 2-р улирлаар, бизнесийн үнэлгээний тайланг 2010 оны 3-р улирлын тайлангаар тасалбар болгон гүйцэтгүүлсэн. Тайланг 2010 оны 12 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн гаргасан болно.

Анхааруулга: Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлангийн гүйцэтгэлийн огноо 2010 оны 2 болон 3-р улирлаар тасарч хийгдсэн болно!

Хөрөнгийн үнэлгээний тухай:

Хөрөнгийн үнэлгээний зорилго

“Силикат” ХК-ийн өмчлөлд байгаа үл хөдлөх ба хөдлөх хөрөнгүүдийн өнөөгийн бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлгээний зорилго оршсон.

Хөрөнгийн үнэлгээ нь санхүүгийн тайлагналын болон тус компанийн бизнесийн үнэлгээний зориулалтаар хийгдсэн. Үнэлгээний тайлан, тооцоо, үр дүнг санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд тусгахад зориулав.

Үнэлгээний арга зүй

Барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг зардлын болон зах зээлийн жишиг үнийн хандлагаар, зам талбай, хашаа, гадна сантехникийн байгууламжуудыг зардлын (төсвийн) аргаар тооцож нэгдсэн үнэлгээний санал гаргасан.

Компанийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн үнэлгээний нэгдсэн товчоо

№	Хөрөнгийн нэр	Балансаар 2010/06/30		Шинэчилсэн үнэлгээ			
		Бүгд дүн	Үлдэгдэл өртөг	Орлуулалтын өртөг	Элэгдэл	Дахин үнэлсэн дүн	Зохицуулалт хийгдсэн шинэчилсэн үнэлгээ
1	Барилга	376 684,93	142 035,35	4 867 803,33	1 977 662,60	2 890 140,72	2 521 554,77
2	Байгууламж	93 781,68	74 386,26	945 504,65	532 436,87	413 067,78	342 420,91
3	Тоног төхөөрөмж	786 929,34	652 719,57	1 302 004,96	211 156,39	1 090 848,57	1 081 684,65
4	Тээврийн хэрэгсэл	242 580,00	159 723,62	344 181,07	82 726,15	261 454,92	231 229,25
5	Тавилга эд хогшил	36 618,48	27 867,85	43 098,51	11 510,56	31 587,95	31 587,95
6	Компьютер, дагалдах хэрэгсэл	22 855,15	3 785,01	22 855,15	15 863,38	6 991,77	6 991,77
7	НИЙТ	1 559 449,58	517,67	7 525 447,66	2 831 355,95	4 694 091,71	4 215 469,30

Хүснэгт 13 Хөрөнгийн үнэлгээний товч

Компани нь хөрөнгийн үнэлгээнд тулгуурлан Сүлд аудитын компанийн зөвлөмжийн дагуу 2010 оны 3-р улирлын тайлан тэнцэлдээ анхны өртгөөс үнэлэн 7 525 447,70 төгрөгөөр тусгаж харуулсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 5/240 тоот албан бичгээр

өгсөн зөвлөмжийн дагуу зээлийн хүүгийн төлбөрийг тусган, үлдэгдэл өртгөөс үнэлэн 2010 оны 4-р улирлын тайлан тэнцэлд залруулга хийж 4,317,237,722.84 төгрөгөөр бүртгэлд тусгасан болно.

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗАСВАР ОРУУЛСАН БАЛАНС

	/мянган.төгрөг/	
ҮЗҮҮЛЭЛТ	2009.12.31	2010.06.30
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	705,00	1 181,10
Авлага	29 866,70	48 274,90
Бараа материал	610 505,20	758 255,30
Урьдчилж төлсөн тооцоо	90 000,00	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	731 076,90	807 711,30
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1 545 249,50	7 525 447,70
	- 400	
Хуримтлагдсан элэгдэл	485,30	- 3 309 978,40
Биет бус хөрөнгө	3 378,50	93 378,50
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1 148 142,70	4 308 847,80
НИЙТ ХӨРӨНГӨ	1 879 219,60	5 116 559,10
ӨГЛӨГ БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өглөг		
Дансны өглөг	149 280,40	213 910,90
Цалингийн өглөг	-	1 752,90
ААНОАТ-н өглөг	221,20	221,20
ХХОАТ-н өглөг	21 237,70	13 245,20
НӨАТ-н өглөг	-	3 708,10
Бусад татварын өглөг	448,80	424,80
ЭМНДШ-н өглөг	-	5 117,70
Банкны богино хугацаат зээл	1 491 526,30	1 454 249,70
Банкны зээлийн өглөг	-	264 023,90
Бусад өглөг	110 816,80	110 816,80
Богино хугацаат өглөгийн дүн	1 773 531,20	2 067 471,20
Урт хугацаат өглөг		
Урт хугацаат өглөг	-	-
Урт хугацаат өглөгийн дүн	-	-
Нийт өглөгийн дүн	1 773 531,20	2 067 471,20
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал	17 012,60	17 012,60
Дахин үнэлгээний нөөц	430 305,10	3 595 287,80
	- 341	
Хуримтлагдсан үр дүн	629,30	- 563 212,50
Эзэмшигчдийн өмчийн дүн	105 688,40	3 049 087,90
НИЙТ ӨГЛӨГ БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	1 879 219,60	5 116 559,10

Хүснэгт 14 Хөрөнгийн үнэлгээний засвар оруулсан баланс

Бизнесийн үнэлгээний тухай:

“Силикат” ХК нь нэмэлт хувьцаа гаргах болсонтой холбоотойгоор “Үндэсний Реалти” ХХК нь тус компанийн бизнесийн үнэлгээ буюу нэгж хувьцааны зах

зээлийн өнөөгийн үнэлгээг 2010 оны 09 дүгээр сарын 30-ны өдөрөөр тасалбар болгон Олон улсын үнэлгээний стандарт, арга хандлага, аргачлалын дагуу бие даасан хараат бус байдалд хийж гүйцэтгэсэн.

Бизнесийн үнэлгээний тайланг

- Өртгийн хандлагын арга
- Орлого капиталжуулалтын хандлагаар
- Зах зээлийн харьцуулалтын хандлагаар үнэлсэн байна.

Үнэлгээний компани нь бизнесийн үнэлгээний зорилго, зориулалтаас хамаарч үнэлгээний арга сонголт, үр дүн, давуу болон дутагдалтай талуудыг шинжилж үзээд ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох аргаар хийсэн бизнесийн үнэлгээнд 60 хувийн ач холбогдол өгч, өртгийн хандлагын аргаар үнэлгээг хийхдээ тухайн бизнесийн үйл ажиллагаа нь өөрчлөн зохион байгуулагдах, татан буугдахгүй цаашид үргэлжлэх учир цэвэр хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээнд 30 хувийн ач холбогдол, зах зээлийн харьцуулалтын хандлагын салбарын коэффициентийн аргаар хийсэн үнэлгээнд зах зээл дээрх мэдээллийн хомсдолтой байдал, байгаа мэдээллийн бодит байдалд нийцэх, найдвартай байдал, тухайн салбарын компаниудын хөрөнгийн зах зээл дээрх идэвхитэй бус үйл ажиллагаа зэргийг харгалзан тус аргад 10 хувийн ач холбогдол өгч үнэлсэн байна.

<i>Үнэлгээний арга</i>	<i>2010/09/30 /мян.төг/</i>	<i>Ач холбогдол</i>	<i>Тооцсон дүн</i>
Цэвэр хөрөнгийн арга	3 321 283,1	30%	996 384,93
Орлогын хандлагын арга	9 968 453,0	60%	5 981 071,78
Зах зээлийн харьцуулалтын	2 005 591,5	10%	200 559,15
	15 295 327,6	100%	7 178 015,9

Хүснэгт 15 Бизнесийн үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн бизнесийн өнөөгийн үнэ цэнийг дунджаар 7 178 015,9 (Долоон тэрбум нэг зуун далан найман сая арван таван мянга есөн зуун) мянган төгрөгөөр тодорхойлсон ба гүйлгээнд байгаа нийт 170 126 ширхэг энгийн хувьцаанд харьцуулахад нэгж хувьцааны үнэ цэнийг 42 200 төгрөгөөр тодорхойлсон.

1.14 ҮНЭТ ЦААС ГАРГАЖ САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох элс, шохойн чулууны орд бүхий талбайд хайгуул хийх, ашиглалт явуулах эрхийг олгосон тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг.

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Цогт” нэртэй газарт 24.9 га талбайд ашигт малтмал ашиглах 14949А дугаартай тусгай зөвшөөрлийг 2009 оны 06 дугаар сарын 23-ны өдөр олгожээ. Тусгай зөвшөөрлийн хугацаа 30 жил тусгай зөвшөөрлийн 2 дахь жилийн төлбөрийг 2010 оны 03 дугаар сарын 31-ны өдөр төлсөн байна.
- Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт Сайхан нэртэй газарт 31 га талбайд хайгуул хийх тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Уг тусгай зөвшөөрлийг ГУУКГ-ын даргын 2008 оны 966 тоот шийдвэрээр “Дарсилбет”ХХК-иас шилжүүлэн авсан байна. Тусгай зөвшөөрлийн анх олгохдоо 2009 оны 12 дугаар сарын 26-ныг хүртэлх хугацаагаар олгосон боловч ГУУКХ-ийн даргын 2010 оны 550 тоот шийдвэрээр тусгай зөвшөөрлийн хугацааг 2010 оны 12 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаагаар сунгажээ. Ашигт малтмалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэхь хэсэгт заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар 2 удаа сунгуулах эрхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгосон байдаг. Иймд мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан журмын дагуу холбогдох материалаа бүрдүүлэн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах боломжтой.

Үнэт цаас гаргагч нь дээрх 2 тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу эзэмшиж байгаа бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаж байгаа тул тусгай зөвшөөрөл цуцлагдах ноцтой шалтгаан байхгүй байна.

Төслөөр баригдах үйлдвэр нь бүрэн шаталттай, үнслэгийг сорох тусгай төхөөрөмжтэй орчин үеийн технологитой тул байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай экологийн цэвэр үйлдвэрлэл юм. Энэ нь хууль эрх зүйн хувьд ямар нэгэн эрсдэлгүй байх эерэг талтай.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь доорх хуулиудын хүрээнд зохицуулагддаг. Үүнд:

- | | |
|--|---|
| - Авто тээврийн болон өөрө явагч хэрэгслийн албан татварын хууль | - Нягтлан бодох бүртгэлийн тухай |
| - Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай | - Үнэт цаасны зах зээлийн тухай |
| - Ашигт малтмалын тухай | - Үйлдвэрчний эвлэлүүийн эрхийн тухай |
| - Байгаль орчиныг хамгаалах тухай | - Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай |
| - Барилгын тухай хууль | - Хөдөлмөрийн тухай хууль |
| - Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах хууль | - Стандарчлал тохирлын үнэлгээний тухай |
| - Гаалийн тухай | - Татварын хууль |
| - Геодез зураг зүйн тухай | - Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай |
| - Даатгалын тухай | - Эрчим хүчний тухай хууль |
| - Компанийн тухай хууль | |
| - Нийгмийн даатгалын хууль | |

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

2.1 ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцааны төрөл: Энгийн

Нэрлэсэн үнэ: 100 ₮

Зах зээлд санал болгох ширхэг: 16 222 300

Компанийн хэдэн хувь болох: 35%

Санал болгох үнэ: 225 ₮

Арилжаалах хэлбэр: Монголын хөрөнгийн биржээр дамжуулан, нээлттэй зах зээл дээр захиалгын бүртгэлийн аргаар санал авч олон нийтэд арилжаална.

Урьдчилан тохирсон гэрээний дагуу: Андеррайтерын компани нь нэмж гаргаж буй хувьцааны 50% буюу 8 111 150 ширхэг хувьцааг зах зээлд санал болгох анхны үнэ болох 225 төгрөгөөр худалдан авна.

2.2 ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ШИЙДВЭР

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 34, 39, 63, 84 дүгээр зүйл, компанийн дүрмийн 6 дугаар зүйлийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын 5 тоот тогтоол, 2011 оны 04 дүгээр сарын 07-ны ТУЗ-ийн хурлын 3 тоот тогтоол, 2011 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын 2 тоот тогтоолын дагуу нэмэлт хувьцаа гарган компанийн дүрмийн санг нэмэгдүүлэн, нэмэлт санхүүжилт татаж байгаа болно.

Нэмж хувцаа гаргах асуудлаар хэлэлцсэн 2010 оны 08 дугаар сарын 16 болон 2011 оны 5 дугаар сарын 1-ний хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, тус асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь Монгол улсын компанийн тухай хуулийн 54, 55-р зүйлийн дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааг үнэт цаас гаргах шийдвэр гарах үеийн зах зээлийн ханшаар эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.

2.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын “Компанийн тухай” хууль, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулиудад заасан болон компанийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчийн эрхийг эдлэнэ. Компанийн дүрэмд зааснаар хувьцаа эзэмшигчид нь дараах эрхтэй.

1. Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
2. Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:
 - 1/ Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах эрх бүхий этгээдээс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 2/ ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа компанийн

- буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
- 3/ Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
- 4/ Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Энэ давуу эрхийг эдлэх боломжийг Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ хангана.
3. Хувь нийлүүлэгчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Үүнд:
- 1/ Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
- 2/ Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
- 3/ Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
4. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно. ТУЗ-өөс тогтоосон үнэ нь үнэлгээний байгууллагын дүгнэлтэд заасан үнээс доогуур байж болохгүй.
5. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч болон эзэмшигчид нь жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д нэр дэвшүүлэх эрхтэй.
6. Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тухай энэ дүрэмд заасан эрхээ эдлэх баталгаа болно.
7. Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 болон 96 дугаар зүйлийн 96.1, 96.2-д заасан бичиг баримтуудтай энгийн хувьцаа эзэмшигч бүр танилцах эрхтэй.

8. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцааг эзэмшигчид нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй.
9. Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
10. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.
11. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс зааглагдсан болно.

2.4 УРЬД ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь 1992 онд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 170 126 ширхэг хувьцаатай 17 012,6 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар байгуулагдсан.

Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн судалгаа

<i>Үзүүлэлт</i>	<i>Хувьцаа эзэмшигч</i>	<i>Хувьцааны тоо</i>	<i>Эзэмшиж буй хувь</i>
5-с дээш хувийн хувьцаа эзэмшигч	5 хувьцаа эзэмшигч	166 573 ширхэг хувьцаа	97,9%
Компанийн 5 хувь хүртэлх хувийн хувьцаа эзэмшигч	19 хувьцаа эзэмшигчид	3 553 ширхэг хувьцаа	2,1%

Хүснэгт 16 Хувьцаа эзэмшигчдийн судалгаа

СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ СУДАЛГАА

Арилжаалагдсан ширхэг	109
Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	0,06%
Үнийн дүн	60 400
Жигнэсэн дундаж ханш	600
Дээд үнэ	800
Доод үнэ	115
Хаалтын ханш /2010.12.15/	800

Хүснэгт 17 Хувьцааны арилжаа судалгаа



Зураг 5 Хувьцааны арилжаалагдсан ширхэг, үнэ

Хувьцааны ихэнх хувь нь төвлөрсний улмаас зах зээл дээрх хувьцааны арилжаа зогсч, зах зээлийн үнэлгээ компанийн үйл ажиллагаанаас хамаарч өөрчлөгдөх боломжийг хязгаарласан учир зах зээлийн үнийг бодит бус гэж үзэн хувьцааны шинэчилсэн үнийг тогтоож байна.

2.5 ХУВЬЦААНЫ ШИНЭЧИЛСЭН ҮНЭ ТОГТООХ

Шинэчилсэн үнэ тогтоох үндэслэл

Үнэт цаас гаргагч нь 1992 онд МХБ-д бүртгэгдэн хувьчлагдсан ба хувьцааны одоогийн төвлөрөл нь 98 хувь байна. Энэ нь хувьцааны зах зээл дээрх үнийн хөдөлгөөн явагдах боломжийг хязгаарласан.

Өнөөдөр компанийн эзэмшигчдийн өмчийн дүн 3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд компанийн нийт гаргасан хувьцаатай нь харьцуулахад хувьцааны зах зээл дээрх үнийг шинэчлэн тогтоох шаардлага тулгарч байна. Учир нь хувьцааны дансны үнэ нь зах зээлийн үнээс хэт илүү болсон байгаа нь зах зээлийн үнэ бодитой бус байгаа гэж үзэж байгаа юм.

Тооцоо

ОДОО БАЙГАА	
Эзэмшигчийн өмчийн дүн	3 022 363 935.35
Нийт гаргасан хувьцаа	170 126
Нэгж хувьцааны үнэлгээ	17 765
Нэгж хувьцааны дансны үнэ	17 765

Хүснэгт 18 Шинэчилсэн үнэ тогтоох тооцоо

Дансны үнийг тооцоолохдоо нийт хөрөнгөөс ер төлбөрийн дүнг хасч цэвэр эзэмшигчдийн өмчийн дүнгээр тодорхолсон.

Үндэслэл

Компанийн тухай хуулийн 52 болон 63-р зүйлийн дагуу компанийн эрх барих дээд байгууллага болох хувь нийлүүлэгчдийн хурлын тус асуудлаарх саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар энэхүү төслийг хэрэгжүүлэх бүрэн үндэслэл бүрдсэн болно.

Хувьцаа хуваах үндсэн нөхцөл

Хувьцаа хуваах шийдвэрийг компанийн хөрөнгийн үнэлгээг хийлгэж, уг үнэлгээнд үндэслэн тооцоог хийж, хувьцаа хуваах төслийг компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулснаар хувьцаа хуваах нөхцөл бүрдэнэ. Шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулан хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна. Улмаар “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон “Монголын хөрөнгийн бирж” ХК дахь үнэт цаасны болон компанийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

Зорилго

Одоогийн удирдлагын баг 2004 онд компанийн нийт гаргасан хувьцааны 98%-ийг төвлөрүүлэн авснаас хойш 6 жилийн хугацаанд зах зээл дээр тус компанийн 109 ширхэг хувьцаа арилжигдаж байсан болно. Хувьцааны хэт өндөр төвлөрөл нь зах зээл дээр хувьцаа чөлөөтэй арилжаалагдаж компанийн бодит үнэлгээг хөрөнгө оруулагчдаар үнэлүүлэх үндсэн нөхцлийг үгүй болгосон.

Компанийн хувьцааг хувааснаар хувьцааны төвлөрлийг бууруулах, зах зээлд хувьцаа чөлөөтэй арилжаалах суурь нөхцлийг бүрдүүлж, компанийг зах зээлийн зарчмаар хөрөнгө оруулагчдаар үнэлүүлнэ.

Шийдвэр

Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 4 тоот тогтоол, 2011 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн 1 тоот тогтоолын дагуу компанийн хувьцааны зах зээл дэх арилжааг идэвхижүүлэх зорилгоор нэгж хувьцааг 177 ширхэгт хуваахаар шийдвэрлэсэн.

Ач холбогдол

Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад бий болох давуу тал, түүний ач холбогдол

- ✓ Эзэмшиж буй хөрөнгө нь зах зээл дээр чөлөөтэй хөрвөх чадвартай болох
- ✓ Хувьцааны зах зээл дээрх арилжааны идэвхи компанийг зах зээлийн жишгээр бодитоор үнэлэх боломж олгосноор хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнэ өсөх
- ✓ Компанид хараат бус хөндлөнгийн хяналт бий болж, компанийн засаглал сайжирснаар хөрөнгө оруулагчдын хөрөнгө илүү үр ашигтай байх.
- ✓ Компани нь хувьцаа хувааж нэмэлт хувьцаа гарган санхүүжилт татаж үйлдвэрийг өргөжүүлснээр үйлдвэр ашигтай ажиллах нөхцөл бүрдэх ба үүнээс хөрөнгө оруулагчид ногдол ашиг хүртэх

Компанид бий болох давуу тал, ач холбогдол

- ✓ Компани зах зээл дээр бодитоор үнэлэгдэх боломжтой болно
- ✓ Хувьцаа хуваагдсаны дараа нэмэлт хувьцааг зах зээл дээр захиалгын бүртгэлийн аргаар нийлүүлэх ба энэ нь компанийн өнөөгийн үнэ цэнийг хөрөнгө оруулагчдаар үнэлүүлж, үнэ цэнийг өсгөх боломж бүрдэнэ.
- ✓ Компанийн бүтээмжийг үнэлсэн зах зээлийн үнэлгээнд үндэслэн нэмэлт санхүүжилт татах, улмаар компанийн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломж
- ✓ Нэмэлт хувьцаа гарган зах зээлд байршуулснаар хувьцааны төвлөрөл буурах улмаар компанид хараат бус удирдлага бий болох, ТУЗ-н бүрэлдэхүүн шинэчлэгдэх, компанийн засаглал сайжирна.
- ✓ Хувьцаа хувааж нэмэлт санхүүжилт татсанаар компанийн өр төлбөр төлөгдөж санхүүгийн чадавхи нэмэгдэх
- ✓ Үйлдвэрийн технологийг шинэчлэн сайжруулснаар үйлдвэрлэлийн өртөг буурч хямд үнэтэй, чанартай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, зах зээлд эзлэх өөрийн байр суурийг нэмэгдүүлэх


Тооцоо

ОДОО БАЙГАА	
Эзэмшигчийн өмчийн дүн	3 022 363 932
Нийт гаргасан хувьцаа	170 126
Нэгж хувьцааны үнэ /дансны үнээр/	17 765
Нэгж хувьцааны шинэчилсэн үнэ	100
Хувьцаа хуваах тооцоо	177=1

ХУВЬЦАА ХУВААСНЫ ДАРАА	
Нийт гаргасан хувьцаа	30`112`302
Нэгж хувьцааны үнэ	100
Зах зээлийн үнэлгээ	3 011 230 200

Хүснэгт 19 Хувьцаа хуваах тооцоо

2.8 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГА ХЭЛБЭР, ГРАФИК



Зураг 6 Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр

Нэмж гаргаж буй Үнэт цаасыг анхдагч зах зээлд хосолсон аргаар байршуулах ба 2010 оны 08 дугаар сарын 16-ны хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэсний дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй.

Нэмж гаргах хувьцааны **50%-ийг Андеррайтерын компани анхдагч зах зээл дээрээс олон нийтэд худалдах үнээр худалдан авч** үлдэх 50%-ийн хувьцааг Санхүүгийн Зохицуулах Хорооны “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай” журмын 4.6.3, 4.12-т заасны дагуу **Захиалгын бүртгэл хийх аргаар** анхдагч зах зээлд байршуулна.



Зураг 7 Хувьцааны захиалга

Нэмж гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлд байршуулахдаа андеррайтерын компанийн худалдан авч буй хувьцааны хуваарилалтыг хийсний дараа захиалга өгсөн, биелэх боломжтой захиалга тус бүрээр үнэт цаасны хуваарилалтыг хийнэ.

Захиалгын бүртгэлийн аргаар анхдагч зах зээлд байршуулах график

Захиалгын бүртгэлийн аргаар санал болгох хувьцааны анхдагч зах зээлд байршуулах үнийг тогтоохдоо тус үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жигнэсэн дундаж үнэ, үнэт цаас борлуулалтаас олохоор төлөвлөсөн хөрөнгийг бүрэн бүрдүүлэх боломжит үнэ, аль болох олон хөрөнгө оруулагчийг хамруулах үнэ зэргийг харгалзан Андеррайтер, Үнэт цаас гаргагч компани хамтран тогтооно. Анхдагч зах зээлд байршуулах үнэ, ширхэгийг тогтоон хувьцааг байршуулсны дараа хуваарилагдаагүй үлдсэн хувьцааг зарласан боловч эргэлтэд гаргаагүй хувьцаа гэж тооцон бүртгэнэ.

	1 дахь долоо хоног	2 дахь долоо хоног	3 дахь долоо хоног	4 дахь долоо хоног	5 дахь долоо хоног	6 дахь долоо хоног	7 дахь долоо хоног
СЗХ-ний тогтоол, МХБ-ийн бүртгэл	Үнэт цаасыг олон нийтэд санал болгох нөхцөл бүрдэх						
Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах		Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, брокерийн компаниудын цахим хуудас, и-мэйл зэргээр танилцуулга хийх					
Захиалга авах, хаах				Брокер дилерийн компаниудаар дамжуулан доод үнийг 225 төгрөг болон түүнээс дээш үнээр ажлын 5 хоногийн хугацаанд захиалга авах бөгөөд захиалгыг долоо хоногийн сүүлийн ажлын өдрийн үнэт цаасны арилжааны цаг дуусмагц хаана.			
Захиалга дүгнэх, үнэ тогтоох					Нийт захиалгыг хүлээн авч анхдагч зах зээлд худалдах үнийг ажлын 3 хоногт багтаан зах зээлийн эрэлтэд тулгуурлан үнэт цаас гаргагч болон андеррайтер хамтран тогтооно.		
Арилжаалах зөвшөөрөл авах					Анхдагч зах зээлийн арилжаа хийх зөвшөөрөл авах хүсэлтийг ажлын 2 өдөрт багтаан СЗХ-нд гаргана		
Анхдагч зах зээлийн арилжаа						Зөвшөөрөл олгогдсоноос хойш ажлын 2 хоногт багтаан МХБ-ийн үнэт цаасны арилжаагаар хувьцааг нийтэд худалдах ажиллагааг зохион байгуулна	
Тайлан гаргаж СЗХ-нд өгөх						Үнэт цаасны арилжааны тайланг СЗХ-нд гарган өгөх ба ХНХ зарласан мэдээллийг хавсарган хүргүүлнэ	
ХНХ болох							Хурал зарласнаас хойш 30 хоногийн дараа хуралдана

Хүснэгт 20 Анхдагч зах зээлд байршуулах цаг хугацааны график

1. Энэхүү арилжаа нь Санхүүгийн зохицуулах хорооны “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам” болон Монголын Хөрөнгийн Биржийн “Анхдагч зах зээлийн арилжааны журам”-аар зохицуулагдан хийгдэнэ.
Захиалгын бүртгэл хийх аргаар анхдагч зах зээлд байршуулах үнэт цаасыг олон нийтэд ажлын 10 хоногт танилцуулга хийсний дараа ажлын 5 хоног брокер дилерийн компаниудаар дамжуулан нээлттэй захиалга авна. Мэдээллийг Захиалгын бүртгэл эхлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө брокер дилерийн компаниудад хүргүүлж, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр нийт 10-аас доошгүй удаа зарлана.
2. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь харилцан тохиролцож, санал болгох үнийн доод хязгаарыг 225 төгрөг гэж тогтоосон.
3. **Хувьцааны олон нийтэд санал болгох үнийг нийт захиалга дээр үндэслэн тогтоох ба таны өгсөн захиалгын үнэ тогтоосон үнээс доош бол таны захиалга биелэгдэхгүй болно. Хэрэв нийт захиалгын хэмжээ олон нийтэд санал болгож буй хувьцаанаас илүү гарсан тохиолдолд таны захиалсан хувьцааны хэмжээ хувь тэнцүүлэн буурч олгогдоно гэдгийг анхаарна уу.**
4. Үнэт цаас гаргагчаас үнэт цаасыг олон нийтэд амжилттай санал болгон шаардлагатай санхүүжилтийг босгосны дараагаар МХБ-ийн журмын дагуу үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх ба энэ үед хувьцаа худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа зарж борлуулах эрх нээлттэй болно.

Үнэт цаасыг хэрхэн худалдан авах вэ?

Хөрөнгө оруулагч Та үнэт цаасыг худалдан авахын тулд “Үнэт цаасны танилцуулга” хийгдсэнээс 2 долоо хоногийн дараах ажлын 5 хоногийн хугацаанд 225 төгрөг болон түүнээс дээш үнээр, тодорхой тооны үнэт цаас худалдан авахаар захиалга өгч болохоос гадна, үнэ, тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнгийн хэмжээг зааж өгч болно. Нийт үнийн дүнгийн хэмжээг заасан захиалгыг анхдагч зах зээлд байршуулах үнэ хэдээр ч тогтсон байршуулсан үнийн дүндээ тохирсон тооны үнэт цаас худалдан авна гэсэн хүсэл зоригийн илэрхийлэл гэж ойлгоно.

Захиалгыг брокер дилерийн компаниар дамжуулан хүлээн авна. Бүртгэгдсэн захиалгыг баталгаажуулах зорилгоор захиалга өгөхдөө барьцаа хөрөнгийг /захиалгын үнийн дүнгийн 30-аас доошгүй хувиар/ үнэт цаасны дансандаа байршуулах бөгөөд захиалга хаахаас 24 цагийн өмнө захиалга хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрэн байршуулсан байна.

Таны захиалсан үнэт цаасны төлбөрт зориулсан барьцаа хөрөнгийг арилжаа хийгдэх хүртэл тусгаарлах арга хэмжээ авна.

Захиалгын маягтыг бүрэн бөглөж, худалдан авах үнэт цаасны төлбөрийг үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан бөгөөд арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд орсон захиалгыг хүчин төгөлдөр болсонд тооцно.

Үнэт цаасны захиалга авах хугацаа дуусах өдрийн арилжааны цаг дууссан буюу тус өдрийн 13 цагаас хойш нэмж захиалга авахгүй болохыг анхаарна уу.

Үнэт цаасны захиалга авах хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан үнэт цаасны худалдах үнийг тогтоож, биелэх боломжтой захиалга тус бүрээр үнэт цаасны хуваарилалтыг хийнэ. Энэ үед захиалга өгсөн этгээдийн дансанд үнэт цаасыг байршуулахгүй бөгөөд урьдчилсан байдлаар тухайн захиалагчид ногдох хувьцааны тоо ширхэгийг тогтооно.

Үнэт цаасыг хэн худалдан авах вэ?

Энэхүү үнэт цаасны арилжаа нь Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны арилжаагаар явагдах бөгөөд та үнэт цаасны арилжаанд оролцохын тулд аливаа нэг брокерийн компанид үнэт цаасны данс нээлгэсэн байх шаардлагатай.

Үнэт цаасны дансыг хувь хүн, аж ахуй нэгж байгууллага гэсэн 2 ангилалтайгаар нээх бөгөөд гадаад, дотоод гэсэн ялгаа байхгүй болно.

Данс нээх талаар Та брокерийн компаниудаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

Татвар, шимтгэл

Үнэт цаасны арилжаанд ороход Та нийт гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар шимтгэл төлөх ба энэ шимтгэл нь таны данс нээлгэхдээ тогтоосон шимтгэлийн дүн байх болно. Тухайлбал таны дансны шимтгэл 3 хувь байвал 1,000,000 төгрөгний хувьцаа худалдан авахад 30,000 төгрөгний шимтгэл төлнө гэсэн үг.

Иймд хөрөнгө оруулагч нь дансандаа үнэт цаас худалдан авах дүн болон шимтгэлийн төлбөрийн нийлбэртэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан байна.

Хувь хүний дансан дахь хувьцаанд ногдол ашгийн татвар ногдуулах:

“Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 30.2 дугаар зүйл “энэ хуулийн 13.1.3, 13.1.4-т заасан орлогод 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан татвар ногдуулна” гэж заасан ба 13.1.3 “ногдол ашгийн орлого” ба 13.1.4 “хүүгийн орлого” гэж тодорхойлжээ. Иймд иргэн, хувь хүн ногдол ашгийн орлогод 2013 он хүртэл татвар төлөхгүй.

Аж ахуйн нэгж байгууллагын дансан дахь хувьцаанд ногдол ашгийн татвар ногдуулах:

“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 16.3 “Дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдуулах тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно”, 16.3.1 “ногдол ашгийн орлого”, 17.2 “Албан татвар төлөгчийн дараахь орлогод дор дурдсан

хувиар албан татвар ногдуулна”, 17.2.1 “ногдол ашгийн орлогод 10 хувиар” гэж заагдсан.

Иймд ногдол ашгийн орлого олсон байгууллага нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар ногдол ашгийн орлогоосоо 10 хувиар татвар ногдуулж төлнө.

Хувьцаа борлуулснаас олсон ашгаас татвар төлөх:

Хувьцаа борлуулсан тохиолдолд албан татвар төлөх орлогыг тодорхойлохдоо худалдсан үнээс худалдан авсан үнийг хасч худалдах болон худалдан авахад төлсөн шимтгэлийг хасч тодорхойлно.

Хувь хүн аж ахуйн нэгж нь дээрх дүнгээс 10 хувиар тооцон орлогын албан татвар төлнө.

Төгрөгийн ханш

МХБ-ийн арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр (MNT) хийгдэнэ. Ханшийг тухайн өдрийн зах зээлийн ханшаар тооцно. Арилжааны банкууд төгрөгтэй харьцах гадаад валютын ханшийг өдөр бүр шинэчлэн тогтоож олон нийтэд зарладаг.

Монгол Улсын томоохон арилжааны банкуудын ханшийн мэдээлэл авах цахим хуудас.

Голомт Банк: www.golombank.com

ХААН Банк: www.khanbank.com

Төрийн Банк: www.statebank.mn

Худалдаа Хөгжлийн Банк: www.tdbm.mn

Хадгаламж Банк: www.savingsbank.mn

Хувьцаа худалдан авах мөнгийг хэрхэн байршуулах вэ?

Хөрөнгө оруулагч худалдан авах хувьцааны үнийн дүн болон арилжааны шимтгэлийн нийлбэр дүнгээс багагүй хэмжээний мөнгөн хөрөнгийг дансандаа байршуулсан байна.

Дансандаа мөнгө байршуулахдаа ҮЦТТХТ-ийн арилжааны банкин дахь данс рүү нь шилжүүлгээр хийнэ.

Үнэт цаасны дансандаа банкны шилжүүлгээр мөнгө байршуулах нь танд аль ч улсаас мөнгө шилжүүлэн хийх боломжийг олгож байгаа. Хамгийн гол нь Та төлбөрийн зориулалтан дээрээ брокерийн компанид нээлгэсэн өөрийн үнэт цаасны мэдээлийг бүрэн тусгах хэрэгтэй.

ҮЦТТТХТ ХХК-ийн дансны дугаар

Хүлээн авагч байгууллагын нэр: ҮЦТТТХТөв ХХК

Хүлээн авагч банк: Голомт банк
Хүлээн авагчийн дансны дугаар: 1102017223
SWIFT code: GLMTMNUB

Хүлээн авагч банк: Хаан банк
Хүлээн авагчийн дансны дугаар: 5082007254
SWIFT code: AGMOMNUB

Хүлээн авагч банк: Төрийн банк
Хүлээн авагчийн дансны дугаар: 3413000658
SWIFT code: STBMMNUB

Хүлээн авагч банк: Худалдаа хөгжлийн банк
Хүлээн авагчийн дансны дугаар: 499138239
SWIFT code: TDBMMNUB

Хүлээн авагч банк: Хадгаламж банк
Хүлээн авагчийн дансны дугаар: 10000018669
SWIFT code: SVBMMNUB

2.9 Хувьцааны эргэлтийг түгжих буюу хувьцаа тусгаарлах /LOCK UP/

Төсөл санаачлагчид болох компанийн одоогийн хяналтын багц эзэмшигчид болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн эзэмшиж буй “Силикат” ХК-ийн хувьцааг анхдагч зах зээлийн арилжаа явагдсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд арилжаанд оролцуулахгүй тусгаарлана.

2.10 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗАМААР ХУРИМТЛУУЛАХ ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, ЭДИЙН ЗАСАГ ҮР АШГИЙН ТООЦОО

Нэмж гаргаж буй үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын зарцуулалт

Санал болгох хувьцааны ширхэг	16 222 300
Санал болгох доод үнэ	225
Татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй дүн	3`650`000`000

Хүснэгт 21 Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Компани үнэт цаасаа олон нийтэд санал болгон татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах зүйлд зарцуулна.

Зарцуулалт	Үнийн дүн	Хувь
1. Өр төлбөр барагдуулах	1 436 210 000	39,4%
2. Чулуу бэлдэх уулын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд	653 944 000	17,9%
3. Шохойн үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх	1 267 846 000	34,7%
4. Санхүүжилтын зардал	292 000 000	8,0%
НИЙТ	3 650 000 000	100%

Хүснэгт 22 Хөрөнгө оруулалтын зарцуулалт

- Үйл ажиллагааны өргөжилтөнд зориулан Зоос банкнаас авсан зээлийн төлбөрт санхүүжилтийн 39,3% буюу 1 436 210 000 төгрөг зарцуулагдана. Нэмэлт санхүүжилтээс урд үүссэн өр төлбөрийг барагдуулж байгаа нь хөрөнгө оруулагч та урд нь хийгдсэн хөрөнгө оруулалтаар боссон бизнесээс худалдан авч байгаа ойлголт юм.
- Компани нь шохойн үйлдвэрийн шинэчлэлд зориулан нийт хөрөнгө оруулалтын 34,7% буюу 1 267 846 000 төгрөг зарцуулахаар тус тус төлөвлөж байна.
- Шохойн чулуу бэлдэх уулын ажилд зориулан 653,946,000 төгрөг буюу нийт хөрөнгө оруулалтын 17,9%-ийг зарцуулна. Уулын ажилд шаардлагатай машин тоног төхөөрөмжийн худалдан авалт болон тэсэлгээ хөрс хуулалт, ТЭЗҮ зэрэгт зарцуулагдана.

Хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх үйл ажиллагааны цаг хугацааны төлөвлөгөө

Хоног	30 хоног	60 хоног	90 хоног	120 хоног	150 хоног	180 хоног
Зээлийн төлбөр	500 000 000,00	500 000 000,00	436 210 000,00			
Санхүүжилтийн зардалд			292 000 000,00			
Шохойн үйлдвэр	ТТ-ийн захиалга,	200 000 000,00	226 800 000,00			
	ТТ хүлээн		152 097 703,00			
	Барилгын ажил		25 000 000,00		400 000 000,00	
	Тоног төхөөрөм			77 400 000,00		
	Гааль			70 000 000,00		
	Угсралтын зардал				73 788 297,00	
	Туршилт					42 760 000,00
	Бульдозер, ковш,	463 750 000,00				
Чулуу бэлдэх	Бутлуур, шигшүүр,	101 696 000,00				
	Угсралт			44 500 000,00		
	Тэсэлгээ, хөрс				44 000 000,00	
	БҮГД НИЙТ	3 650 002 000,00				

Хүснэгт 23 Үйл ажиллагааны төлөвлөгөө

1. Өр үүссэн шалтгаан, санхүүгийн тайланд хэрхэн тусгагдсан талаар

Үнэт цаас гаргагч нь бизнес төлөвлөгөөний дагуу өөрийн 2 үйлдвэрийг шинэчлэн өргөтгөл хийх зорилгоор Зоос банкнаас 2007 – 2008 онд дараах зээлүүдийг авч 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,45 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Огноо	Зээл олгогч	Зээл олголт	Зээл төлөлт	Үлдэгдэл
07.07.05	Зоос банк	441 115 000,00	832 003,43	440 282 996,57
08.03.13	Зоос банк	1 041 240 503,39	141 240 503,39	900 000 000,00
08.07.18	Зоос банк	200 000 000,00	86 033 327,01	113 966 672,99
Нийт				1 454 249 669,56

Хүснэгт 24 Зээлийн мэдээлэл

- 2007 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Зоос банкыг төлөөлж 102 дугаар салбарын захирал А.Энхчимэг, эдийн засагч Ч.Мөнхбаяр, “Силикат” ХК-ийн захирал Ц.Содбилэг нар гэрээ байгуулан 21 тоот зээлийн гэрээгээр 441,115,000 төгрөгийг сарын 1,7%-ийн хүүтэй 24 сарын хугацаатай хөнгөн бетоны үйлдвэрт технологийн болон парк шинэчлэл хийх зээлэнд хамрагдсан. Зээлийг зориулалтын дагуу ашиглаж хөнгөн бетоны үйлдвэрт шаардлагатай нэмэлт сайжруулалт хийснээр бүрэн механикжсан ба парк бүрэн шинэчлэгдсэн.
- Төслийн нэг дэх шат амжилттай хэрэгжсэнээр банк 2 дахь шатлалын зээл олгохыг зөвшөөрч 2008 оны 03 дугаар сарын 12-нд 34 сарын хугацаатай, сарын 1,5%-ийн хүүтэй 2 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр гарч 08 тоот зээлийн гэрээ байгуулсан.
Зоос банк 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08 тоот зээлийн гэрээний дагуу 2008 оны 03 дугаар сараас 2008 оны 04 дүгээр сар хүртэл хөрөнгө оруулалтын зээлийн гэрээний дагуу 900 сая төгрөгийн зээл олголт хийж, Зоос банкны үйл ажиллагаа доголдсоноор зээлийн шугамыг хааж, зээл олголтыг зогсоосон. Зээлдэгч банк гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж зээл олголтыг хийгээгүйгээс зээлдэгч байгууллага хэрэгжүүлж байсан төслөө бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна.
- Хоёрдахь шатны зээл олголт бүрэн хийгдээгүйгээс компанийн төлөвлөж байсан ажлуудад санхүүжилтын хүндрэл гарч 2008 оны 07 дугаар сарын 18-нд “Зоос” банктай 16 тоот зээлийн гэрээг байгуулан сарын 2,5%-ийн хүүтэй богино хугацаат зээлийг авсан.

Зээл олгогч банкны үйл ажиллагаа доголдсоноор 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн 650 тоот тушаалаар “Зоос” банкны үйл ажиллагааг зогсоож, бүрэн эрхт төлөөлөгчөө томилсон. Удирдах дээд байгууллагын шийдвэрээр банкны үйл ажиллагааг бүрэн зогсоож, эрх зүйн бүрэн чадамжгүй болсон өдрөөс банкны үйл ажиллагаа эрхэлж зээлд хүү бодох үндэслэлгүй. Монгол банкны бүрэн эрхт төлөөлөгч 2010 оны 07 дугаар сарын 26-ны өдөр “Силикат” ХК-ийн зээлийг шүүхэд шилжүүлснээр зээлийн хүү бодолт албан ёсоор зогссон болно.

Зээлийн зарцуулалт

“Силикат” ХК нь бизнес төлөвлөгөөний дагуу Зоос банкны зээлээр

1. Хөнгөн бетоны хүчин чадлыг нэмэгдүүлэх,
2. Шохойн үйлдвэрт шаардагдах технологийн чулууг бэлдэх, карьерын тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулан ажиллуулах,
3. Шохойн үйлдвэрийн техник технологи дамжлагын тоног төхөөрөмжийг сайжруулах төлөвлөгөөтэйгээр ажилласан.

Зоос банкны зээлийн санхүүжилт хаагдаж, компанид бүрэн санхүүжилт орж ирээгүй учир технологийн шинэчлэл бүрэн хийгдээгүй. Зээлийн санхүүжилт нь дараах үйл ажиллагаанд зарцуулагдсан байна.

- 2008 онд хөнгөн бетоны үйлдвэрлэлийн хүчин чадлыг 80%-иар нэмж, шохойн 4 зуухыг их засварт оруулан нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан
- 2009 онд шохойн чулууг бутлан ангилж ялгах тоног төхөөрөмж худалдан авч суурилуулсан.


Компанийн сүүлийн 3 жилийн болон үнэт цаас гаргах хүсэлт гаргахын өмнөх улирлын буюу 2010 оны жилийн эцсийн Аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт, Банкны өр барагдуулах албаны тодорхойлолтууд хавсралтад тусгагдсан болно.

Зээлийн зарцуулалтыг дэлгэрэнгүйгээр харуулбал:

Зээл авсан огноо	2007 оны 7 сар		2008 оны 3 сар		2008 оны 7 сар		Нийт хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалтын нийт зээлд эзлэх хувь
	Үнийн дүн	Зээлд эзлэх хувь	Үнийн дүн	Зээлд эзлэх хувь	Үнийн дүн	Зээлд эзлэх хувь		
Зээлийн зарцуулалт								
1 Хөнгөн блокны үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	261,343,846	59.20%	162,910,000	14.7%	2,454,545	1.2%	426,708,391	24.3%
2 Шохойн үйлдвэрт шаардагдах технологийн чулууг бэлдэх, карьерын тоног төхөөрөмжийг худалдан авч суурьлуулах	143,876,000	32.59%	672,776,186	60.6%			816,652,186	46.6%
3 Шохойн үйлдвэрийн техник, технологи дамжлагын тоног төхөөрөмжийг сайжруулах	34,074,000	7.72%	135,683,995	12.2%	199,829,763	98.8%	369,587,758	21.1%
4 Оффисын тохижилт	2,175,200	0.49%	49,095,380	4.4%			51,270,580	2.9%
5 Үйлдвэр ашиглалтын зардал			89,534,439	8.1%			89,534,439	5.1%
Нийт дүн	441,469,046	100%	1,110,000,000	100%	202,284,308	100%	1,753,753,354	100.0%

Хүснэгт 25 Зээлийн зарцуулалтын мэдээлэл

Хөрөнгө оруулалтын нийт зээлд эзлэх хувь



- Хөнгөн блокны үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Шохойн үйлдвэрт шаардагдах технологийн чулууг бэлдэх, карьерын тоног төхөөрөмжийг худалдан авч суурьлуулах
- Шохойн үйлдвэрийн техник, технологи дамжлагын тоног төхөөрөмжийг сайжруулах
- Оффисын тохижилт
- Үйлдвэр ашиглалтын зардал

Зураг 8 Хөрөнгө оруулалтын задаргаа

2. Шохойн чулуу бэлдэх уулын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх

“Силикат” ХК нь өөрийн үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох шохойн чулууг Дархан Уул аймгийн Хонгор сумын нутаг дахь “Цогт” шохойн чулууны 5-р ордыг эзэмшин олборлолт хийнэ.

Тус орд нь 14949А тусгай зөвшөөрөлтэй 24,9 га талбайтай. Үүний ¼-д буюу 5 га-д хайгуул хийн нөөцийн хэмжээг 1,2 сая тн гэж тодорхойлогдсон. Уурхай жилд дунджаар 86,000 тн шохойн чулуу олборлоно гэж тооцож 2010-2014 онуудад ашиглалт явуулах ТЭЗҮ боловсруулагдсан.

ОРДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО

	Ш	Хүчин чадал	НБҮ	НБҮ, юань	Дүн	Нийт
Бульдозер	1		\$ 200 000		250 000 000	
Машин	2		\$ 52 000		130 000 000	
Ковш	1		\$ 67 000		83 750 000	463 750 000
Хацарт бутлуур	1			100 000	19 600 000	
Шигшүүр	1			34 000	6 664 000	
Конвейер	3	30м x 80см		54 000	31 752 000	
Конусан бутлуур	1			80 000	15 680 000	
Бункер	2	100м3			28 000 000	101 696 000
Угсралт Бетон зуурмаг		100м3			12 000 000	
Арматур		26тн			25 000 000	
Цалин хөлс Туслах материал					2 500 000	
Газар шорооны ажил		100м3			5 000 000	44 500 000
Уулын ажил						
Тэсэлгээ					10 000 000	
Хөрс хуулалт					14 000 000	
ТЭЗҮ					20 000 000	44 000 000
НИЙТ					653 946 000	653 946 000

Хүснэгт 26 Хөрөнгө оруулалтын тооцоо

Хөрөнгө оруулалтын бүтцийн 13%-ийг барилга байгууламж буюу агуулах складууд, 16%-ийг удирдлагын зардал буюу машин, техник, сандал, ширээ, 23%-ийг хөрс хуулах техникүүд, 45%-ийг хүдэр олборлох техникүүд, 3%-ийг цахилгаан үүсгүүрийн зардлууд эзлэж байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

№	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
		2010	2011	2012	2013	2014
1	Цалин	54,350	130,440	130,440	130,440	130,440
2	НДШ	7,065.50	16,957.20	16,957.20	16,957.20	16,957.20
3	Завсар үйлчилгээ	24,256.90	41,025.30	42,639.30	42,437.50	44,782.60
4	Түлш шатахуун	60,642.40	102,570.80	106,598.30	106,093.70	111,956.4
5	Тослох материал	9,096.40	15,385.60	15,989.70	15,914.00	0
6	Хөдөлмөр хамгаалал	6,711	6,711	6,711	6,711	6,711
7	Аж ахуйн зардал	2,325	5,580	5,580	5,580	5,580
8	Дугуйн зардал	550	1,100	1,100	1,100	1,100
9	Бичиг хэргийн зардал	750	1,800	1,800	1,800	1,800
10	БО, нөхөн сэргээлт		22,500	22,500	22,500	22,700
11	Ашиглалтын үеийн хайгуул			37,500		
12	Элэгдэл	19,628.50	47,108.60	47,108.60	47,108.60	47,108.60
13	Цахилгаан	5,026.20	12,763.10	12,763.10	12,763.10	12,763.10
14	Өрөмдлөгийн ажил	17,013.30	31,268.10	31,268.10	31,268.10	28,515.50
15	Тэсэлгээний	18,513.00	30,392.20	18,462.00	20,344.70	18,267.80
Нийт ашиглалтын зардал		225,928	465,605	497,418	461,018	465,475
Бүтээгдэхүүний хэмжээ /мян.тн/		41	86	86	86	86
1ТН-ИЙН ӨРТӨГ		5510	5,414	5,783	5,360	5,412

Хүснэгт 27 Бүтээгдэхүүний өртөг

Шохойн чулууны 5-р ордыг ашиглах ТЭЗҮ-ийг 4,5 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн ба энэ хугацаанд 20,529 м3 хөрс хуулж, 142,931 м3 хүдэр олборлон баяжуулж жилд дунджаар 86 мянган тн шохойн чулуу олборлохоор тооцоход бүтээгдэхүүний өөрийн өртөг дунджаар 5,110 төгрөгтэй гарч байгаа нь 1тн шохойн чулууны зах зээлийн үнэ болох 9500 төгрөгтэй харьцуулахад дариу 46%-иар хямд байна.

“Силикат” ХК нь шохойн чулууны 5-р ордыг ашиглах төсөлд **653,9 сая** төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээр өөрийн бүтээгдэхүүний үндсэн түүхий эдийг зах зээлийн үнээс 46%-иар хямд үнээр авч ашиглах боломжтой болно.

3. Шохойн үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх

Компани нь үнэт цаас гарган нэмэлт санхүүжилт татсанаар шохойн үйлдвэрлэлийн технологийг шинэчилж жилд 33,400 тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай болно.

ТЕХНОЛОГИЙГ ШИНЭЧЛЭН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

Одоо ажиллаж байгаа үйлдвэрлэлийн бааз, дэд бүтцэд тулгуурлан өндөр чанартай, бага өртөгтэй, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх сүүлийн үеийн технологитой үйлдвэрийг Монголын шохойн үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэн ашиглах нь төслийн нэг үндэслэл болж байна.

Энэхүү шохойн үйлдвэрийг ашигласнаар:

- Шохойн үйлдвэрийн үндсэн түүхий эд нүүрс, шохойн чулууны технологийн ашиглалт 65-75% байсан бол нүүрс нь 100%, шохойн чулууны ашиглалт 90% болно.
- Шохойн өөрийн өртөг буурч, чанар сайжирсанаар шохойн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- Экологийн цэвэр үйлдвэрлэл явагдаж дутуу шаталтаас үүсэх нүүрс хүчлийн хийн ялгаралт эрс буурна.
- Шохойн чанар, стандарт олон улсын түвшинд хүрнэ.
- Шохойн чанар, хямд өртгийг дагаж хөнгөн бетон блокны чанар сайжирч өртөг хямдрана.
- Карьерийн бутлах, ангилах үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт дээшилнэ.
- Чанар дагаж борлуулалт нэмэгдсэнээр, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт 100%-д хүрнэ.
- Дотоодын зах зээлийг хангаад зогсохгүй, бүтээгдэхүүнээ экспортлох бололцоотой.

Монгол Улсын Засгийн газрын 2020 хүртэлх хөгжлийн төлөвлөгөөнд аж үйлдвэрийн парк гэж тусгагдсан Дархан уул аймгийн үйлдвэрлэлийн районд байрлах “Силикат” ХК нь үндэсний чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэгээрээ олны итгэлийг дааж зах зээлд танигдсан салбартаа томоохон үйлдвэрлэгч юм.

Одоогоор манай улсын шохойн хэрэглээний 90 гаруй хувийг дотоодын үйлдвэрлэгчид хангаж байна. Үлдсэн хувийн сайн чанарын шохойг БНХАУ-аас оруулж байна. Дотоодын шохой үйлдвэрлэгчдийн ашиглаж буй техник технологи, түүхий эдээс хамаарч бүтээгдэхүүний чанар стандарт хэрэглэгчдийн шаардлагыг төдийлэн сайн хангаж чадахгүй байна.

Монгол Улсын засгийн газраас баримталж буй мөрийн хөтөлбөр нь бидний зорилтот зах зээлийг өргөжүүлэх бололцоог олгож байгаа. Тухайлбал, хүн амыг орон сууцжуулах, уул уурхай, аж үйлдвэрийн цогцолбор, металлургийн завод, боловсруулах үйлдвэр гэх мэт. Зах зээлийн эрэлтийг угтан өндөр чанартай, өртөг хямд шохойг үйлдвэрлэн өөрийн бүтээгдэхүүнээр зах зээлд манлайллыг бий болгох боломжийг энэхүү төслөөр баригдах үйлдвэр хангаж

өгнө. Хөрөнгө оруулалтаар баригдах шохойн үйлдвэр нь түүхий эд ашиглалтын коэффициент өндөртэй, эрчим хүчний болон хөдөлмөр зарцуулалтын зардал бага, бүтээмж өндөр, сайн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх тул хэрэглэгчдийн эрэлтэнд бүрэн нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай шохойг үйлдвэрлэнэ.

Зах зээлийн хандлага

Монгол Улсын засгийн газрын 2010/06/25-ны өдрийн 36 тоот тогтоолоор “Шинэ барилгажилтын хөтөлбөр” баталсан. Хөтөлбөрт хамрагдаж буй төслүүд: “100 000 айлын орон сууц”, “Барилгын материал үйлдвэрлэлийн төслүүд”, “Утаагүй Улаанбаатар”, “Хөдөөгийн хөгжил” төсөл.

Төслийн санхүүжилт нь дараах шат дарааллаар хийгдэхээр төлөвлөгдсөн:

2010 – 2012 эхний үе шат	8,8 их наяд төгрөг
2013 – 2016 дараагийн үе шат	9,4 их наяд төгрөг

Уул уурхайн салбарын өсөлт: 2010 онд боловсруулах үйлдвэрийн салбар 29,6%, олборлох үйлдвэрийн салбарт 42,6%-ийн өсөлттэй байсан.

Дээрх нөхцөл байдлууд нь үндсэн түүхий эд болох идэвхжсэн шохойн зах зээлийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж байна. Зах зээлийн энэхүү бодит өсөлт нь үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт болон эдийн засгийн ашигт ажиллагааг дээшлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа. Цаашид улс орны эдийн засгийн өсөлттэй уялдан, бидний үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ жилээс жилд улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа, бид эдийн засгийн ашигт ажиллагаанд үндэслэн зах зээлийн өсөн нэмэгдэж буй эрэлттэй уялдуулан үйлдвэрлэлийн хүчин чадлыг жил тутам нэмэгдүүлэхийг зорьж ажиллана.

Шохойн гол хэрэглэгчид

Хэрэглэгч	Төвийн бүсийн хэрэгцээ, тонн	Одоогийн нийлүүлэлт	Цаашдын зорилт
Эрдэнэт Үйлдвэр	40 000		10 000
Бороо Гоулд	11 000	6 000	11 000
Дарханы төмөрлөгийн үйлдвэр	8 000		8 000
Арьс шир боловсруулах үйлдвэрүүд	6 000	2 000	4 400
Хөнгөн бетон ХК	5 000		2 000
Силикат ХК	5 000	1 000	8 000
УБХБ	5 000		
Улиастай	5 000		
Яармаг	3 000		
Авто	3 000		
Хөтөл ХБ	3 000		
Нийт	104 000		43 400

Хүснэгт 28 Бүтээгдэхүүн хэрэглэгч

Үнэт цаас гаргагч нь өнөөгийн байдлаар жилд 9 000 тонн шохой буюу нийт зах зээлийн хэрэгцээний 8,6 хувийг үйлдвэрлэн гаргаж байна. Энэ нь үйлдвэрлэлийн хүчин чадлын 30 орчим хувь байгаа бөгөөд үйлдвэрлэлийн болон борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байгаа.

Шохой

Боловсруулсан шохой нь барилгын материал үйлдвэрлэлийн гол түүхий эд төдийгүй уран, цайрын болон өнгөт металл боловсруулах үйлдвэр, алтны уурхайнуудад баяжуулалтын гол түүхий эд болдгоороо стратегийн чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн юм.

2008-2009 онд олборлосон шохойн чулууны ордын бүхэл шохойн хими эрдсийн найрлага нь доор дурьдсан хэмжээнд байсан.

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт		
		S-1	S-2	S-3
Идэвхи /CaO+MgO/	%	63,84	82,88	75,6
CO ₂ -ийн хэмжээ	%	2,68	0,78	1,16
Туналтын температур	град.цельс	38,0	52,0	55,0
Тунасан хугацаа	мин	7,0	7,0	5,0
Гидратын хэмжээ	%	0,45	0,93	0,87
MgO-ийн хэмжээ	%	0,96	1,34	0,38
Тунаагүй хэсгийн хэмжээ	%	1,85	0,95	1,08

Хүснэгт 29 Олборлосон шохойн чулууны ордын бүхэл шохойн эрдсийн найрлага
Дээж авалтын тэмдэглэл S-1 талбай-1, S-2 талбай-2, S-3 талбай-3

2010-2015 онд ашиглахаар төлөвлөж буй шохойн чулууны ордын шохойн чулууны хими эрдсийн найрлага

Дээжийн дугаар	Карбонатад хамаарах исэлийн агуулга, %				Үндсэн эрдсийн агуулга
	CaO	MgO	ШГХ	Бусад хольц	
Tso-1	53,48	0,38	42,55	3,59	CaCO ₃ -95,50
Tso-2	54,04	0,19	42,79	2,98	CaCO ₃ -96,50
Tso-3	53,20	0,19	41,97	4,64	CaCO ₃ -96,00
Tso-4	53,20	0,58	42,19	4,03	CaCO ₃ -95,00

Хүснэгт 30 Ашиглахаар төлөвлөж буй шохойн чулууны ордын шохойн чулууны эрдсийн найрлага

Дээж авалтын тэмдэглэл Tso өрмийн дугаар.

Дээрх ордын хими эрдсийн найрлага нь уул уурхайн салбарт баяжуулах үйлдвэрүүдийн хүдэр баяжуулах технологийн орчин тохируулагч гол түүхий эдийн болзлыг бүрэн хангаж байгаа.

Үнэт цаас гарган татан төвлөрүүлсэн санхүүжилтээр үйлдвэрлэлийн төслийн хүчин чадлыг 3,3 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлснээр тус компанийн бүтээгдэхүүний чанар доор дурьдсан хэмжээнд хүрнэ.

CaO %	MgO %	Уусаагүй үлдэгдэл %
90-95	0-2	0-2

Хүснэгт 31 Бүтээгдэхүүний чанар

Энэхүү төслийн үр дүнд манай улсад өндөр хүчин чадлаар үйлдвэрлэгч хамгийн том шохойн үйлдвэр бий болно. Шохой шатаах үйл ажиллагааны горим нь карбонат кальцийг өндөр температурт шатааж кальцийн исэл ба нүүрсхүчлийн хий болгон задлах явц юм. Шохойны үйлдвэрлэлийн хувьд шохойн чулууг бүрэн гүйцэд шатаах нь хамгийн гол үзүүлэлт байдаг. Дутуу шаталт буюу уусаагүй үлдэгдэл нь бүтээгдэхүүний өртөгийг өсгөж, чанарт нөлөөлсөнөөр хэрэглэгчдийн эдийн засгийн үр ашиг багасдаг сул талтай.

Шохойн зуухыг шинэчилсэнээр

Үзүүлэлт	Хуучин бүтээгдэхүүн	Шинэ бүтээгдэхүүн
Хүчин чадал	30 тн/хоногт	100 тн/хоногт
Өртөг	Өндөр	Хямд
Идэвхжил	60-80 хувь	80 хувиас дээш
Уусаагүй үлдэгдэл	3%	0-2%
Экологийн цэвэр байдал	Дунд зэрэг	Сайн
Нүүрс ашиглалт	60-70%	100%
Технологийн чулуу ашиглалт	60-70%	100%

Хүснэгт 32 Шохойн зуухыг шинэчилсэнээр бүтээгдэхүүний чанар

ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО

Үзүүлэлт	ХН	Хэмжээ	НБҮ	Нийт үнэ
Тоног төхөөрөмж				
1 Барилга	М2	1600	\$200	425,000,000
2 Үйлдвэрийн тт	Ком	1	¥2,200,000	426,800,000
3 Хацарт бутлагч	Ш	1	¥23,870	4,630,780
4 Туузан дамжлага	Ком	1	¥12,139	2,354,966
5 Шоматон тоосго	Тн	160	¥2,300	71,392,000
6 Галд тэсвэртэй материал	Тн	20	¥5,000	19,400,000
7 Уур үүсгэгч зуух	Ш	1	¥200,000	38,800,000
8 Шохойн тээрэм	Ш	1	¥80,000	15,520,000
9 Угсралтын зардал	15%			73,788,297
10 Тээврийн зардал	Эрээн		¥150,000	29,100,000
11 Гаалийн зардал				70,000,000
12 Тээврийн зардал	Дархан			48,300,000
13 Туршилт				42,760,000
Бүгд				1,267,846,043

Хүснэгт 33 Шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо

Шинэ шохойн зуухыг БНХАУ-ы Henan Hongke Heavy Machinery Co.,Ltd –с авахаар урьдчилсан тохиролцоо хийгдсэн ба бид хөрөнгө оруулалтын зарцуулалтын тооцоог 2010/06/20-ны байдлаар хийсэн болно.

ТООЦООЛСОН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Борлуулалтын орлого	2 525 737	5 951 137	6 985 440	7 157 347	7 608 604
Өсөлтийн хувь	500	500	000	313	008
ББӨ	107%	136%	17%	2%	6%
Өсөлтийн хувь	2 063 595	3 577 459	3 971 464	3 969 199	4 048 519
Өсөлтийн хувь	952	969	559	243	792
Өсөлтийн хувь	106%	73%	11%	0%	2%
Үйл ажиллагааны ашиг	462 141 548	2 373 677 531	3 013 975 441	3 188 148 070	3 560 084 216
Өсөлтийн хувь	109%	414%	27%	6%	12%
Үйл ажиллагааны зардал	210 008 691	253 019 427	320 712 937	316 396 608	312 549 433
Өсөлтийн хувь	82%	20%	27%	-1%	-1%
Хүү ногдол ашгийн өмнөх ашиг	252 132 857	2 120 658 104	2 693 262 504	2 871 751 462	3 247 534 783
Өсөлтийн хувь	138%	741%	27%	7%	13%
Хүүгийн төлбөр	-	-	-	-	-
Өсөлтийн хувь	-100%	-	-	-	-
Ногдол ашиг	50 426 571	424 131 621	538 652 501	574 350 292	649 506 957
Өсөлтийн хувь		741%	27%	7%	13%
Татварын өмнөх ашиг	201 706 285	1 696 526 483	2 154 610 003	2 297 401 169	2 598 027 826
Өсөлтийн хувь	363%	741%	27%	7%	13%
Татварын зардал	20 170 629	169 652 648	215 461 000	229 740 117	259 802 783
Өсөлтийн хувь	363%	741%	27%	7%	13%
Цэвэр ашиг	181 535 657	1 526 873 835	1 939 149 003	2 067 661 052	2 338 225 044
Өсөлтийн хувь	363%	741%	27%	7%	13%

Хүснэгт 34 Тооцоолсон орлогын төлөвлөгөө

ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

ҮЗҮҮЛЭЛТ	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
	хувь	хувь	хувь	хувь	хувь
Борлуулалт	100,00	100,00	100,00	100,00	100,00
ББӨ	81,70	60,11	56,85	55,46	53,21
Үйл ажиллагааны ашиг	18,30	39,89	43,15	44,54	46,79
Үйл ажиллагааны зардал	8,31	4,25	4,59	4,42	4,11
Хүү ногдол ашгийн өмнөх ашиг	9,98	35,63	38,56	40,12	42,68
Хүүгийн төлбөр	-	-	-	-	-
Ногдол ашиг	2,00	7,13	7,71	8,02	8,54
Татварын өмнөх ашиг	7,99	28,51	30,84	32,10	34,15
Татварын зардал	0,80	2,85	3,08	3,21	3,41
Цэвэр ашиг	7,19	25,66	27,76	28,89	30,73

Хүснэгт 35 Орлогын тайлангийн бүтэц

МӨНГӨН УРСГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

	2011	2012	2 013	2014	2015
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	4 420 066	671 212 336	845 395 307	2 692 754 996	4 849 786 089
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	2 525 737 500	5 951 137 500	6 985 440 000	7 157 347 313	7 608 604 008
Нийт мөнгөн орлого	2 530 157 566	6 622 349 836	7 830 835 307	9 850 102 308	12 458 390 097
Ажилчдад олгох мөнгө	278 070 000	490 200 000	690 240 000	690 240 000	690 240 000
Нийгмийн даатгал Түүхий эд	33 368 400	58 824 000	82 828 800	82 828 800	82 828 800
материал худалдан авалт	955 129 500	2 146 233 510	2 400 033 510	2 400 033 510	2 484 633 510
Ашиглалтын зардал	644 085 288	776 552 750	762 654 500	777 654 500	787 763 750
Үйл ажиллагааны зардал	67 000 000	90 000 000	112 000 000	112 000 000	112 000 000
Бусад зардал	102 693 800	121 360 000	121 210 000	130 210 000	136 210 000
Орлогын албан татвар	20 170 629	169 652 648	215 461 000	229 740 117	259 802 783
Хөрөнгө оруулалт	1 921 791 043	1 000 000 000	-	-	1 500 000 000
Ногдол ашиг	50 426 571	424 131 621	538 652 501	574 350 292	649 506 957
Нийт мөнгөн зардал	4 072 735 230	5 276 954 529	4 923 080 311	4 997 057 219	6 702 985 799
Мөнгөний илүүдэл ба дутагдал	- 1 542 577 664	1 345 395 307	2 907 754 996	4 853 045 089	5 755 404 298
Санхүүжилт	3 650 000 000	-	-	-	-
Зээл төлөлт	1 436 210 000	500 000 000	215 000 000	3 259 000	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	671 212 336	845 395 307	2 692 754 996	4 849 786 089	5 755 404 298


Хүснэгт 36 Мөнгөн урсгалын төлөвлөгөө

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

ҮЗҮҮЛЭЛТ	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	
Цэвэр ашиг	181,535,657	1,526,873,835	1,939,149,003	2,067,661,052	2,338,225,044	8,053,444,591
PV	157,863,407	1,154,469,307	1,274,990,469	1,182,288,590	1,162,565,492	4,932,177,265
NPV						1,332,177,265
ROR						24.82%
Хувьцааны ширхэг	46,334,602	46,334,602	46,334,602	46,334,602	46,334,602	
Үнэ	225	225	225	225	225	
EPS	3,92	32,95	41,85	44,62	50,46	
P/E	57,43	6,83	5,38	5,04	4,46	

Хүснэгт 37 Хөрөнгө оруулалтын өгөөж

Компанийн 5 жилийн нийт цэвэр ашгийн өнөөгийн үнэ цэнэ (PV) нь 4,9 тэрбум төгрөг байгаа ба үүнээсээ өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV) нь 1,3 тэрбум төгрөг байна. Компанийн хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь (ROR) нь 24,82 хувьтай гарч байгаа ашгийн хамгийн бага түвшинөөс 9,82 хувиар илүү гарч байгаа тул уг төслийг хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гарч байна.



Зураг 9 Хөрөнгө оруулалтын өгөөж

Үнэ ба ашгийн харьцаа нь тухайн компанийн хувьцааны эрэлтийг харуулдаг гол үзүүлэлт бөгөөд хувьцааны нэгжид ногдох нэг төгрөгийн ашигт хөрөнгө оруулагчид хэдэн төгрөг төлж байгааг харуулдаг. “Силикат” ХК-ийн хувьд энэ харьцаа 57.43, 6.83, 5.38, 5.04, 4.46 гэх мэтээр буурсан үзүүлэлттэй байгаа нь жил ирэх бүр компанийн ашигт ажиллагаа нэмэгдэж, нэгж хувьцаанд ногдох боломжит ашгийн түвшин хурдацтай өсч байгаатай холбоотой. Зах зээлд идэвхитэй арилжаалагддаг компаниудын хувьд тухайн үзүүлэлт нь 15-с бага байхад хөрөнгө оруулагчдын сонирхолыг татахуйц үзүүлэлт болдог тул дээрх тооцоолсон үнэ ашгийн харьцаа нь хөрөнгө оруулагчдын хувьд таатай үзүүлэлттэй байна.

Энгийн хувьцаанд хөрөнгө оруулагчид нь оруулсан хөрөнгөөсөө ногдол ашиг авах хэлбэрээр эсвэл хувьцааны үнийн өсөлтөөс өгөөж хүртдэг. Силикат ХК-ийн хувьд нэгж хувьцаанд ногдох өгөөж жилд 3.92, 32.95, 41.85, 44.62, 50.46 гэх зэргээр өссөн үзүүлэлттэй байна. Мөн компани нь жил бүрийн ашгийн 20-оос доошгүй хувийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тараахаар төлөвлөсөн болно.

2.11 ТУХАЙН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ, ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ

2.9.1 Гадаад орчны шинжилгээ

1. Үнэт цаас гаргагчийн салбарын эрсдэл

Уул уурхайн салбар: Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Нээлттэй нийгэм форум, бусад судалгааны газруудын дүгнэлтээр уул уурхай, ашигт малтмалын салбар нь монголын тэргүүлэгч салбар төдийгүй цаашид хөгжих өргөн боломж нээлттэй байгааг дурджээ. Энэхүү салбарт тулгамдаж буй асуудлыг гадаад, дотоодын байгууллагууд дуу нэгтэйгээр хөрөнгө оруулалт татах болон төрийн бодлого, хууль эрхзүйн тогтворгүй байдал хэмээжээ. Жишээ нь гэхэд гэнэтийн ашгийн татвар, тогтвортой байдлын гэрээнүүд зэрэг гэнэтийн өөрчлөлт, шийдвэрүүд олон байсан. Улс орны хөгжлийн тулгуур салбар гэдэг утгаараа салбарын үйл ажиллагаа, зохицуулалтад төр заавал оролцох шаардлагатай болдог ч нөгөө талаас салбарын хөгжил төрийн үйл, ажиллагаатай хэт хараат байгаа нь олон эрсдлийг салбарт авчирч байна.

Өрсөлдөөний ердийн бус нөхцөл байдалтай холбогдсон эрсдэл: Төрийн оролцоо гэдэг утгаараа зах зээлийн бус аргаар өрсөлдөх хэлбэр олон тохиолддог. Ерөнхийдөө бол улс төрийн томоохон хүчнүүд, хөрөнгө ихтэй компаниуд зэрэг хүчтэй оролцогчид энэ салбарт ажилдаг.

Барилгын салбар: Шилжилтийн эдийн засгийн үед зогсонги байдалд ороод байсан Монголын барилгын салбар 2001 оноос эхлэн сэргэж, 2008 он хүртэл эрчимтэй хөгжиж ирлээ. Үүнд Монгол Улсын гадаад худалдааны таатай орчин, банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, хүн амын орлогын өсөлт зэрэг нь эерэгээр нөлөөлсөн. 2003 оноос хойш Монгол Улсын барилгын салбарын жилийн дундаж өсөлт хамгийн багадаа 5.1%-тай байжээ. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар тус салбар нь жилд дунджаар ДНБ-ний 4%-ийг бүрдүүлсэн, өнөөгийн хурдацтай хөгжиж буй аж үйлдвэрийн салбарын нэг нь болжээ.

Барилгын салбарын эрх зүйн зохицуулалтын зохистой орчин, санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдээгүй нь салбарынхаа хөгжлийг гүйцэхгүй эргэлтийг удаашруулах эрсдэлтэй байна.

Үүнд:

- Банкны зээлийн хүүгийн хатуу бодлого тухайлбал богино хугацаатай, өндөр хүүтэй зээл нь удаан хугацаанд үргэлжлэн гүйцэтгэх технологийн циклтэй барилгын байгууллагыг дарамтанд оруулах үндэс болж байна
- Мөн үл хөдлөх хөрөнгөө барьцаалж урт хугацаатай, бага хүүтэй зээл авах боломж хомсдолтой байгаа нь иргэдийн санхүүгийн чадавхийг хязгаарлаж, барилгын борлуулалтыг саатуулж байна.

2. Хяналт зохицуулалт, эдийн засаг, улс төрийн эрсдэл

- а. Валютын ханшны тогтворгүй байдал нь санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөөлж байна. Үүнээс үүдэн санхүүгийн төлөвлөгөө, төсөвт гэнэтийн алдагдал хүлээх эрсдэл өндөр байдаг.

- b. Энэхүү салбарын нийтлэг сул тал нь эцсийн хэрэглэгчдээс үүдэлтэй өрийн сүлжээ үүсч, үйл ажиллагаа доголдох нь их байдаг.
- c. Сэлбэг, шатах тослох материалын үнийн хараат байдал нь бүтээгдэхүүний өртөгт шууд нөлөөлдөг.
- d. Төрийн оролцоо нь зах зээлийн бус аргаар өрсөлдөх тэнцвэрт бус байдлыг үүсгэдэг байдал бий. Жишээ нь, шохойн зах зээлийн өндөр хувийг эзэлдэг Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр нь ерөнхийдөө төрийн өмчит компаниудаас нийлүүлэлт авах сонирхолтой байдаг.
- e. Гадаад эдийн засаг, макро орчноос үүдэлтэй өөрчлөлтүүдийн үед татвар тогтолцоо их дарамт болдог.

3. Тодорхой хязгаарлагдмал хүрээний эсхүл цөөн тооны бэлтгэн нийлүүлэгч, үйлчлүүлэгч, худалдан авагчаас хамааралтай байдлын эрсдэл

- a. Борлуулсан шохойн 40%-ийг уул уурхай, эрчим хүчний салбарт, 20%-ийг хөнгөн бетоны үйлдвэрүүдэд, 40%-ийг арьс ширний үйлдвэрүүд буюу хөнгөн үйлдвэрийн салбарт нийлүүлдэг. Гэвч эдгээрийн аль нэг салбарт бууралт гарахад компанийн нийт борлуулалтанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.
- b. Хөнгөн бетоны борлуулалтын нилээд хувь нь баригдаж буй барилгуудад хөрөнгө оруулалтын байдлаар хийгдэж байгаа бөгөөд энэ нь компанийг эргэлтийн хөрөнгөний дутагдалд оруулах эрсдэл дагуулдаг.

4. Үнэт цаас гаргагчийн бизнестэй холбоотой эрсдлийн талаарх дүгнэлт

- a. Үнэт цаас гаргагчийн бизнесийн салбар нь улсын эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлдэг ба төр болон дотоод, гадаадын байгууллагуудын бүх дэмжлэгийг авах боломжтой.
- b. Энэ бизнес нь олон жилийн туршлага, зах зээлийн эрэлттэй тул ерөнхийдөө хөгжиж буй бизнес юм.
- c. Компанийн үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүний гол зах зээл нь боловсруулсан шохой ба хөнгөн блок юм. Иймд эдгээр бүтээгдэхүүний зах зээл дээрх өрсөлдөөн их байдгаас болж бүтээгдэхүүний үнэ буурвал компанийн ашгийн түвшин болон бүтээгдэхүүний борлуулалт багасах эрсдэл бий.
- d. Эрчим хүчний үнийг төрөөс тогтоодог ба энэ үнийг тооцолсон бизнес төлөвлөгөөнөөс хэтрүүлэн нэмэгдвэл санхүүгийн төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй.
- e. Нүүрсний үнэ нэмэгдэх
- f. Тээврийн зардал нэмэгдэх

5. Хүрээлэн байгаа орчны болон эрүүл ахуйн эрсдэл

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдээс хамгийн их нь утаа, тоос, хөрсний эвдрэл юм. Үүнээс:

- a. Одоогоор Монголд үйлдвэрлэгдэж буй шохойн 40 орчим хувийг баюуны аргаар, 60 орчим хувийг босоо шахт бүхий технологиор үйлдвэрлэж байна. Баюуны арга нь агаарын бохирдлыг хамгийн их

үүсгэдэг тул байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй. Цаашид шинэ дэвшилттэй технолог нэвтрүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах шаардлага өндөр тавигдаж байгаа. Одоо бидний ашигладаг босоо шахт бүхий зуух нь баюуны технологиос үлэмж бага утаа гаргадаг бол цаашид оруулж ирэхээр төлөвлөж буй үйлдвэр бол шаталтын процессийг бүрэн төгс явуулдаг экологийн хувьд маш сайн дэвшилтэт технологтой.

2.9.2 Компанийн дотоод орчны шинжилгээ

1. Санхүүгийн эрсдэл

- a. Бүтээгдэхүүн борлуулах явцад түүхий эд болон тээврийн зардлын нэмэгдлээс хамааралтай төлөвлөсөн зардал хэтрэх,
- b. Зах зээлийн өрсөлдөөнөөс хамааран борлуулалтын төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх,
- c. Эргэлтийн хөрөнгийн хомсдлоос шалтгаалан үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашиглаж чадахгүй байх,
- d. Шинэ барилга, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь төлөвлөж буй хугацаанаас хойш ашиглалтад орох, нийлүүлэгдэх, тасалдах,

2. Хүний нөөц, удирдлагын эрсдэл

- a. Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээс хамааралтай байдлын эрсдэл
 - i. Мэргэжлийн түвшинд үйлдвэрлэлээ авч явахгүй байх нь компанийг харилцагч худалдан авагч нараа алдах, улмаар борлуулалт багасч санхүүгийн хүндрэлд оруулах,
 - ii. Санхүүгийн байдал доголсноор хөрөнгийн зах зээл дэх үнэт цаасны ханш унах эрсдэлтэй,
- b. Ур чадвар, дадлага туршлагатай, мэргэшсэн ажиллах хүчний хангамжтай холбогдсон эрсдэл
 - i. Ажилчдын ажлыг дүгнэх нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байгаа нь ажилдаа мэргэшсэн мэргэжлийн ажилчдыг алдах эрсдэлтэй,
 - ii. Үйлдвэрийн хүчин чадлаас улбаатайгаар боловсон хүчний нөөцөө бүрэн ашиглаж чаддаггүй,
 - iii. Ажиллах нөхцөл хүнд бөгөөд ажилчидын шаардлагыг бүрэн хангаж чаддаггүйгээс үүдэн, чадвартай боловсон хүчинг өөртөө татаж чаддаггүй.

3. Үйл ажиллагааны чухал ач холбогдол бүхий лицензи, тусгай зөвшөөрөл, гэрээний хугацаатай холбоотой эрсдэл

- a. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай олгогддог. Хуулиар тогтоосон жилийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаанаасаа өмнө хүчингүй болж цуцлагдах эрсдэлтэй. Мөн төрийн дээд байгууллагаас ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг нэгдсэн журмаар шинэчлэх шийдвэр гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд өөрчлөлт орно.

- b. Газар эзэмшүүлэх, ус ашиглах гэрээний дагуу тухайн жилийн газар усны төлбөрийг төлөөгүй болон гэрээг дүгнэж шинэчлэн байгуулаагүй тохиолдолд торгуулийн арга хэмжээ ноогдуулах ба хүндэтгэн үзэх шалтгаангүй үед үйлдвэрлэлийн ажиллагааг зогсоох эрсдэлтэй.

4. Үнэт цаасыг худалдан авах ирээдүйн хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлж болох бусад бүхий л чухал үйл явдал

- i. Хөрөнгийн зах зээл болон банкны салбарын тогтвортой бус байдал эргээд хөрөнгө оруулагчдын шийдвэрт сөргөөр нөлөөлж байна.
- ii. Шинээр гарч буй бусад компаниудын үнэт цаасны арилжаа амжилтгүй болж байгаа нь нийт хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахад хүрсэн.
- iii. Үнэт цаас гаргагчаас шалтгаалаагүй ч ихэнхи үнэт цаасны хөрвөх чадвар муу байдаг нь мөн хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээлээс түлхэж байдаг.
- iv. Банкны салбарт хадгаламжийн хүү өнөөг хүртэл маш өндөр (бусад орнуудтай харьцуулахад), хадгаламжийг төр батлан даасан учир хамгийн эрсдэлгүй өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хэвээр байсаар байна.

2.12 ҮНЭТ ЦААСЫГ ЗУУЧЛАГЧ АНДЕРРАЙТЕРЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлдэг “БиДиСЕК” ХК нь 2010 оны 10 сарын 11-ны өдөр “Силикат” ХК-ийн шохойн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, технологийг шинэчлэх, шинэ тоног төхөөрөмж худалдан авах болон санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор нэмэлт санхүүжилт татахад зуучлах андеррайтерын гэрээг байгуулсан.

Уг гэрээний хүрээнд “Силикат” ХК-ийн олон нийтэд гаргасан нийт 170,126 ширхэг хувьцааг 177 ширхэгт хуваан, нэмж 16,222,300 ширхэг хувьцааг зах зээлд 225 төгрөгөөр санал болгон худалдаж 3,6 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх ажил хийгдэх юм.

“БиДиСЕК” ХК нь 1995 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 15 жил үйл ажиллагаа явуулж буй андеррайтер, брокер, дилер хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани юм. Манай компани 2006 оны 6-р сард зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалан хөрөнгийн зах зээл дээрээс 1,0 тэрбум төгрөг, 2008 онд нэмэлт хувьцаа гаргаснаар хөрөнгийн зах зээлээс нийт 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж байна.

Манай компани нь Андеррайтерийн үйлчилгээ үзүүлдэг ууган компаниудын нэг бөгөөд 2005 оны 6-р сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолоор Андеррайтерийн үйлчилгээ эрхэлэх тусгай зөвшөөрөл авсан юм. Монголын Хөрөнгийн зах зээл дээр 2005-2008 онд нийт 13 компани шинээр үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн бөгөөд “БиДиСЕК” ХК нь 8 хувьцаат компанийн Андеррайтераар ажилласан.

Мөн 2004, 2005 онд “Пума групп”-ийн Пума бонд, 2005 онд “Монинжбар” ХК-ийн “Бүтээн байгуулалт бонд”, 2007 онд “Нийслэл өргөө” ХК-ийн “Нийслэл өргөө бонд”-ын ерөнхий зуучлан борлуулагч, 2004 онд “МСиЭС электроникс” ХХК-ийн “МСиЭС электроникс бонд”-ын туслан гүйцэтгэгчээр тус тус ажилласан дадлага туршлагатай.

2.13 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ, ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГАТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХАРИУЦАХ МЭРГЭЖИЛТЭН, ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ



Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
“БиДиСЕК” ХК
www.bdsec.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК” ХК-ний байр

Үнэт цаасны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авч болох хариуцлагатан:

1. Нэр : Ж.Ганболд
Албан тушаал : Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал, “Силикат” ХК
Э-майл хаяг : info@silikat.mn
Холбоо барих утас : 976-70117116
Гар утас : 99151285
2. Нэр : Б.Лхамдолгор
Албан тушаал : Ахлах мэргэжилтэн, “БиДиСек” ХК
Э-майл хаяг: lhamdolgor@bdsec.mn
Холбоо барих утас : 976-11-312030
Гар утас : 976-99010589